Open Ownership

# Эцсийн өмчлөгчийн төв бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгох

## Бодлогын танилцуулга

2021 оны 5-р сар (2022 оны 9-р сард англи хэл дээр хэвлэгдсэн)

**Тойм** 2

**Эцсийн өмчлөгчийн нээлттэй мэдээллийг хэрэглэгч бүлгүүд** 5

Төрийн хэрэглэгчид 5

Хувийн хэвшлийн хэрэглэгчид 6

Иргэний нийгэм 9

**Хэрэгжүүлэгчдийн хувьд бодолцох зүйлс** 13

Төвлөрсөн бүртгэл 13

Мэдээллийн хүртээмж, хэрэглээ 14

Эрх зүйн үндэслэлийг тогтоох 15

Мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосноос гарч болох сөрөг үр нөлөөг дараах байдлаар бууруулах 18

**Дүгнэлт** 22

# Тойм

Мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох асуудал болоод хүний хувийн нууц, аюулгүй байдлын эрсдэлүүдийн талаарх асуудал нь эцсийн өмчлөгчийн (ЭӨ) талаар шинэчлэл хийхэд хамгийн их мэтгэлцээнтэй асуудлуудын нэг юм. Эдгээр чухал, холбоотой асуудлуудыг хэрэгжүүлэгчид анхааралтай авч үзэх шаардлагатай. Эцсийн өмчлөгчийн ил тод байдал (ЭӨИТБ) нь бодлогын хувьд харьцангүй шинэ талбар тул бүртгэлийг олон нийтэд ил болгоход ямар нөлөөлөл гарах вэ гэдэг дээр цугларсан баримт их байхгүй. Гэсэн хэдий ч олон нийтийн бүртгэлийг хэрэгжүүлсэн газруудад баримтууд цугларч байгаа бөгөөд ЭӨ-н мэдээллийг олон нийтэд ил болгохын тодорхой ашиг тусуудыг тодорхойлох боломжтой болж байна.

Сонгууль өгөгчийн бүртгэл[1], барилгын зөвшөөрөл[2] зэрэг тодорхой хувийн мэдээллүүдийг нийтлэх, олон нийтэд ил болгох явдал нь аль хэдийн хэрэгжсэн байдаг бөгөөд энэ нь ерөнхийдөө маргаан дагуулдаггүй. ЭӨ-н мэдээллийг нийтлэх нь хувийн нууцын талаар нэлээдгүй анхаарал болгоомжийг дагуулдаг. Ихэнхи бизнес эрхлэгч санхүүгийн гэмт хэрэгтэй холбогддоггүй учир ЭӨ-г нийтлэх нь бодлогын тодорхой зорилго чиглэлийг хангахад харьцааны хувьд асуудалтай гэж зарим нь үздэг. Харин бусад нь хувийн аюулгүй байдлын эрсдэл бий гэж үздэг. Гэвч олон газар хувьцаа эзэмшигчийн мэдээллийг аль хэдийн олон нийтэд нээлттэй болгосон (зарим үед багахан хураамжаар) бөгөөд ЭӨИТБ шинэчлэл нь илүү нарийн, сэжигтэй байж болох өмчлөлийн бүтэцтэй холбогдсон хүмүүст л нөлөөлдөг гэсэн үг юм. Үүнээс гадна ЭӨ-н мэдээллийг нээлттэй бүртгэлд нийтлэснээс ноцтой хор хохирол гарсан жишээ байхгүй байна.[3]

100 гаруй улс орон ЭӨИТБ-н шинэчлэлийг хэрэгжүүлнэ гэдгээ зарласан бөгөөд 40 гаруй нь 2020 онд нэгдсэн байдаг.[4] Эдгээр шинэчлэлүүд нь хүмүүсийн талаарх мэдээлэл өдөр бүр асар хурдтай цахимжиж буй дэлхийд нийтэд явагдаж байна. Жишээ нь ЕХ-нд бүх гишүүн орныг ЭӨ-н бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгохыг шаардсан захирамж болох Мөнгө Угаахын Эсрэг Тавдугаар Захирамжийг (МУЭТЗ) Ерөнхий Мэдээллийн Хамгаалалтын Зохицуулалт (ЕМХЗ) гэх мэдээллийн хамгаалалтын хамгийн өргөн хүрээг хамарсан хуулийг мөрдөж эхлэхтэй зэрэг баталсан. ЕМХЗ-н үндэслэлээр хувийн нууцыг ЭӨ-н бүртгэлд нийтлэхийн эсрэг хэд хэдэн заргыг шүүхэд гаргасан байдаг. Үүнийг шүүхээр хэлэлцэж байгаа нь чухал бөгөөд гарах үр дүн нь энэ асуудалд хүчтэй нөлөөлөх нь гарцаагүй юм. Мексик зэрэг бусад оронд хүний хулгай болон хувийн аюулгүй байдлын болгоомжлол бий. Эдгээрийг үнэлж дүгнэх шаардлагатай.

Хувийн хийгээд аливаа бусад мэдээллийг ЭӨ-н мэдээллийн задруулгын хүрээнд нийтлэх асуудал дээр мэдэгдэж буй болон мэдэгдэхгүй байж болох тодорхой үр дагаврууд бий. ЭӨ-н мэдээлэл нь хэрэг болох, хүссэн зорилтыг хангахын тулд хувь хүний мэдээллийг агуулж байх ёстой учраас гэрээ хэлэлцээрийн мэдээлэл зэрэг нээлттэй болгож буй бусад багц мэдээллүүдээс өөр юм. Хэрэгжүүлэгч болон ил тод байдлыг дэмжигчид нь боломжит эрсдэлүүд болон тэдгээрийг тодорхой нөхцөл байдалд хэрхэн бууруулах вэ гэдгийг болгоомжтой тооцож үзэлгүйгээр мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохыг шаардаж болохгүй.

Иймд энэхүү бодлогын танилцуулга нь бүх улс орон ЭӨ-н бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгохыг зорих ёстой гэсэн байр суурьгүй болно. Харин мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосноор өөр өөр хэрэглэгчид тухайн мэдээллийг хэрхэн ашиглаж болох вэ, ингэснээр бий болох ашиг тусуудыг тодорхойлох замаар ЭӨ-н бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгосноор бий болох ашиг тусуудыг танилцуулна.

1. **Төрийн байгууллагын хэрэглэгчид дараах ашиг тусыг хүртэх боломжтой:**

   - Төрийн байгууллагын хэрэглэгчдийн мэдээлэлд илүү хурдтай, хялбараар нэвтрэх боломжтой болно;
   - Мэдээллийг нэмэлт бодлогын чиглэлүүдэд ашиглах боломжтой болно;
   - Мэдээллийн хэрэглээг хянах боломж олгоно.

2. **Хувийн хэвшлийн хэрэглэгчид дараах ашиг тусыг хүртэх боломжтой**:
   - эрсдэлийг удирдах, засгийн газрын зохицуулалтыг мөрдөхөд дөхөмтэй болох;
   - бизнесийн орчин дахь итгэлцлийг тэтгэнэ;
   - компаниудын өрсөлдөх талбарыг тэнцвэржүүлнэ;
   - байгаль орчин, нийгмийн засаглалыг сайжруулна (БОНЗ);
   - мэдээллийг дахин хэрэглэснээр эдийн засгийн үнэ цэнийг бий болгоно.
3. **Иргэний нийгмийн хэрэглэгчид дараах ашиг тусыг хүртэх боломжтой**:
   - санхүүгийн гэмт хэрэг, авлигын хэргийг эрэн сурвалжлах;
   - төрийг хянах, хариуцлага хүлээлгэх боломж олгоно;
   - хэрэглээгээр дамжуулан мэдээллийг баталгаажуулах;
   - хуулийн этгээдүүд буруугаар ашиглахаас сэргийлнэ.

Бодлого бодлого боловсруулагч хувьд олон нийтийн бүртгэл нь олон нийтийн ашиг сонирхолд үйлчилнэ гэсэн ойлголтод үндэслэн зөв зохистойгоор хэрэгжүүлж болох хангалттай баримт байгаа гэсэн аргументийг энэхүү танилцуулгаар тавьж байна. Ихэнхи нийтийн бүртгэлүүдийг Европт хэрэгжүүлсэн байдаг тул ихэнхи жишээг Европын орнуудаас авав. Гэсэн ч ашиг тус нь бусад нөхцөл байдалд ч мөн ижил үйлчилнэ. Гарч болох сөрөг нөлөө нь тухайн нутаг дэвсгэрт өөр өөр байх ба үүнийг зохистойгоор ойлгох ёстой.

Иймд энэхүү танилцуулга нь дараах хэрэгжүүлэгчдийн хувьд бодолцох ёстой асуудлуудыгавч дүн шинжилгээ хийнэ. Үүнд:

- ЭӨ-н мэдээллийг **төвлөрсөн байдлаар**нэгтгэн оруулах;
- мэдээллийг ангилалтай, нээлттэй мэдээлэл болгох: төлбөр, биеийн байцаалт, бүртгэлийн шаардлага, бүртгэл ашиглагчийн талаар мэдээлэл цуглуулах эсвэл хязгаарлалт бүхий зөвшөөрөл олгох зэрэг босгогүй **нэвтэрч ашиглах боломжтой**, компани болон эцсийн өмчлөгчөөр хайх боломжтой болгох;
- **эрх зүйн үндэслэл** тогтоож мэдээллийн хамгаалалт, хувийн нууцын хуульд нийцсэн мэдээллийг нийтлэх өргөн хүрээг хамарсан зорилгыг тодорхойлох;
- нийтэлсэнээс **урган гарч болох сөрөг үр нөлөөг дараах байдлаар бууруулах:**
  - зөвхөн зайлшгүй шаардлагатай мэдээллийг цуглуулах (**мэдээллийн цомхон байдал**);
  - дотоодын байгууллагатай харьцуулахад арай бага мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, нарийн нууцлалтай, ашиг тус өгөхгүй мэдээллийг орхих (**давхарга бүхий нэвтрэлт**);
  - хэн нэгэн харьцангүй өндөр эрсдэлд орох магадлалтай нөхцөлд мэдээллийг нийтлэхгүй байх **хамгаалалтын дэглэмийг** хэрэгжүүлэх.

ЭӨИТБ-н шинэчлэлийн эхлэх цэг нь төрийн зүгээс хүрэхийг зорьж буй бодлогын зорилтууд байх ёстой.[a] мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох нь хэр зүй зохистой, ижил тэгш, зөв зүйтэй байх нь бодлогын чиглэл бүрд өөр өөр байна. ЭӨИТБ-г сайн хэрэгжүүлсэн тохиолдолд төрөл бүрийн бодлогын зорилтуудыг хангах боломжтой. Аль болох их бодлогын зорилтыг хангах тусам нийгэмд бий болох ашиг тус нь их байна. Иймд энэхүү танилцуулга нь цогц аргыг ашиглан бодлогын нэжгээд зорилтуудыг тусгахаас гадна мэдээллийн хэрэглээ, хэрэглэгч бүлгүүдийг голчлон авч үзнэ.

[a] Нийтлэг зорилго нь мөнгө угаах, санхүүгийн гэмт хэрэг, авлигатай тэмцэх, түүнчлэн (гадаадын) хөрөнгө оруулалтыг татах явдал юм. Олон тооны засгийн газрууд худалдан авалтад хяналт тавих, хариуцлагын тогтолцоог бий болгохын тулд ЭӨИТБ-ын шинэчлэлийг хэрэгжүүлж байгаа бөгөөд МУЭТЗ нь бизнесийн гүйлгээ, санхүүгийн системийн шударга байдалд итгэх итгэлийг хадгалах талаар онцгойлон дурдсан байдаг.

**Зураг 1.** **ЭӨ-н бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгоход гарч болох сөрөг нөлөөллүүдийг бууруулж ашиг тусыг дээд зэргээр нэмэгдүүлэх**




ЭӨ-н бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгосноор янз бүрийн бодлогын чиглэлд төрөл бүрийн ашиг тусыг авчирдаг төр (Хуудас 5), хувийн хэвшил, (Хуудас 6) иргэний нийгмийн (Хуудас 9) хэрэглэгч бүлгүүдийг нэвтрэх боломжоор хангаж байна гэсэн үг юм.

ЭӨ-н бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгохдоо төр дараах зүйлийг хийх ёстой:

- ЭӨ-н мэдээллийг төвлөрсөн байдлаар нэгтэн оруулах(Хуудас 13);
- мэдээллийг нэвтрэх, ашиглах боломжтой болгох (Хуудас 14);
- баттай эрх зүйн үндэслэлийг бий болгох (Хуудас 16);
- үүсч болох сөрөг үр нөлөөг дараах байдлаар бууруулах:
  - мэдээллийг цомхон байлгах зарчмыг баримтлах (Хуудас 18);
  - шатласан нэвтрэлтийн тогтолцоог хэрэгжүүлэх (Хуудас 19);
  - хамгаалалтын дэглэмийг хэрэгжүүлэх (Хуудас 21).

# Эцсийн өмчлөгчийн нээлттэй мэдээллийг хэрэглэгч бүлгүүд

ЭӨ-н бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгосноор хаалттай бүртгэлтэй дэглэмийн мэдээлэлд нэвтрэх боломжгүй эсвэл хууль, захиргаа, санхүүгийн хязгаарлалтын хүрээнд нэвтрэх эрхтэй тодорхой тооны хэрэглэгч бүлгүүдэд мэдээлэлд нэвтрэх боломжийг олгоно. Эдгээрийг дараах үндсэн бүлгүүдэд ерөнхийлөн ангилах боломжтой:

1. **төрийн хэрэглэгч**, үүнд хууль сахиулах байгууллага, бусад нутаг дэвсгэрийн холбогдох, эрх бүхий байгууллагууд болон нийтлэгч засгийн газрын өөр өөр хэлтэс яамдууд;
2. **хувийн хэвшлийн хэрэглэгч**, үүнд мөнгө угаахын эсрэг (МУЭ) хуулийн хүрээнд үүрэг хүлээсэн, хүлээгээгүй компаниуд болон ЭӨ-н мэдээлэл олгогч, дахин ашиглагчид;
3. **иргэний нийгэм**, үүнд сэтгүүлчид, судлаачид болон олон нийт.

Эдгээр хэрэглэгч бүлгүүд ЭӨ-н мэдээлэлтэй харьцсанаар олон нийтийн ашиг сонирхолд гарч болох ашиг тусуудыг дараах хэсэгт оруулав.

## Төрийн хэрэглэгчид

### Хууль сахиулах байгууллага болон бусад холбогдох эрх бүхий байгууллагууд

Хууль сахиулах байгууллага болон бусад холбогдох эрх бүхий байгууллагууд (татварын газар г.м) нь ихэвчлэн хаалттай бүртгэлтэй дэглэм дэх ЭӨ-н улсын мэдээлэлд нэвтрэх эрхтэй байдаг ч бусад улсын ЭӨ-н олон нийтэд нээлттэй мэдээллийн гол хэрэглэгч бүлэг юм. Санхүүгийн гэмт хэргийн дийлэнхи нь нэгээс дээш улс орныг дамнадаг болдог.[5] Эрх зүйн харилцан дэмжлэг (ЭЗХД) хүссэн хүсэлтийн талаарх мэдээлэл янз бүр байдаг ч Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) хэд хэдэн дүгнэлт, Open Ownership (OO) хууль сахиулах байгууллагуудтай хийсэн яриа хэлэлцээрээс үзэхэд дээрх хүсэлт нь удаан, сунжирсан үйл явц байдаг байна. ФАТФ-н хамтын дүгнэлтийн тайланг Транспэрэнси Интернэшнл (ТИ) хянаж үзээд дараах зүйлийг олж тогтоожээ: “гадны компани оролцсон эсвэл дотоодын компаний өмчлөлийн бүтцийн тодорхой хэсэг нь гадных үед компаний эцсийн өмчлөгчийг тогтооход хүндрэл илүү тулгардаг гэж эрх бүхий байгууллагууд тайлагнадаг. Олон нийтийн ЭӨ-н бүртгэл байхгүй үед маш нарийн төвөгтэй, сунжирсан (ЭЗХД) хүсэлт гарах шаардлагатай болдог” (Нүд 1-г үз) бөгөөд энэ нь хоёр талд маш их зардал дагуулдаг байна.[6] ЭЗХД-н хүсэлтийг амжилттай гаргахад хоёр орны эрх зүйн харьцуулсан сул талууд асуудал үүсгэх явдал бий ажээ. Жишээ нь нийтлэг эрх зүйт болон иргэний эрх зүйт орнуудын хооронд хүсэлт гаргахад шүүгч, хуульчид нь тухайн зөрчил эсвэл хэрэг болон мэдээллийн хүсэлтийг ойлгохгүй байх боломжтой байдаг.

#### Нүд 1: Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллагын харилцан дүгнэлтийн хүрээнд эрх зүйн харилцан дэмжлэг үзүүлэх

2016 онд ФАТФ-н Канад улсад хийсэн үнэлэлт дүгнэлтээр гадаадын этгээдтэй холбоотой эрэн сурвалжлага хийхэд эцсийн өмчлөгчийг тогтоох боломжгүй байх нь олонтаа байсан бөгөөд энэ нь “голчлон Канадын байгууллагын зүгээс эцсийн өмчлөгчийн мэдээллийг олгох талаар гаргасан хүсэлтэд гадаадын орнууд хариу өгдөггүйгээс” үүдэлтэй гэж дурджээ.[7] 2018 онд Гана улсад хийсэн үнэлэлт дүгнэлтэд зарим орнууд хамтран ажиллах сонирхолгүй байдаг, ажлыг удаашруулдаг гэжээ.[8] Хонг Конгод хийсэн үнэлэлт дүгнэлтээр ЭЗХД-н хүсэлтэд хариу ирэх авах нэг жил болдог байна.[9] Эдгээр үнэлэлт дүгнэлтээр гадаад орноос ЭӨ-н мэдээллийг авах хүсэлт гаргахад хууль сахиулах байгууллагад тулгардаг хэд хэдэн асуудлуудыг

тогтоосон, үүнд: мэдээлэл байхгүй байх;[10] тухайн мэдээллийн чанар хангалтгүй байх;[11] тухайн мэдээллийг олон улсад гаргах боломжгүй байх;[12] бусад хуулийн болон хүнд суртлын саадууд.[13]

Үүнээс үүдэн Egmont Бүлэг зэрэг хэд хэдэн олон улсын албан бус мэдээлэл солилцооны механизм гарч ирсэн байдаг. ОО-тэй хийсэн ярилцлагад хууль сахиулах байгууллагын зүгээс нийтийн ЭӨ-н бүртгэлийг эрэн сурвалжлах ажилд асар чухал бөгөөд үнэтэй зүйл гэжээ. Бүртгэл дэх ЭӨ-н мэдээлэл нь шүүхэд ашиглаж болох нотлох баримт болохгүй байж, мөн мэдээлэл 100% үнэн зөв биш байж болох ч компанид “бодит хариуцлага” хүлээдэг хэн нэгний нэртэй байх нь улс дамжсан эрэн сурвалжлагын ажилд асар их тус болдог гэж нэг мөрдөгч хэлжээ.[14] “Хууль сахиулах байгууллагын өнцгөөс харвал ийм бүртгэлд шууд, түргэн шуурхай, хялбар нэвтрэх хэрэгцээ байдаг” гэж Интерполын мэргэжилтэн хэлсэн байна. “Нэг цагдаагийн газраас нөгөө цагдаагийн газарт хил дамнан хүсэлт гаргах, шүүхийн бичиг, хүсэлт бэлтгэж боловсруулах нь маш их цаг, зардал шаарддаг.”[15] Үүнээс гадна ЭЗХД-н хүсэлт амжилттай болоход тухайн мэдээлэлд нэвтрэх шаардлага яагаад үүссэнийг нотлох тодорхой түвшний баримт шаардлагатай болдог. Бүртгэлд шууд нэвтрэх боломжтой байх нь мөрдөн шалгалтыг урьдчилан хийх боломжийг олгодог. ЭӨ-н мэдээллийг улс дамжин шилжүүлэхэд тохирсон дэлхий нийтийн төгс дэд бүтэц байхгүй үед нийтийн бүртгэл нь нэхэн хөөхөөс гадна урьдчилан эрэн сурвалжлах ажлын хүрээнд мэдээлэлд шууд, түргэн шуурхай, хялбар нэвтрэх боломжийг олгоно.

### Бусад төрийн хэрэглэгчид

Төрийн зүгээс олон нийтэд нээлттэй болгосон мэдээллийн гол хэрэглэгчдийн нэг нь төр өөрөө юм.[16] Төрийн янз бүрийн агентлагуудын зүгээс ЭӨ-н мэдээллийг ашиглах, авах хэрэгцээ байх жишээнүүд бий. Төрийн яам хэлтсүүдийн хооронд мэдээлэл дамжуулахад техникийн болон эрх зүйн сорилтууд тулгардаг[17] бөгөөд үүнийг давж гарах нэг арга нь мэдээллийг нээлттэй болгох явдал юм. Жишээ нь Нэгдсэн Вант Улсад ЭӨ-н мэдээллийг шинэ худалдан авалтын системд нэгтгэх санал гарсан. [18] ЭӨ-н мэдээлэл нь олон нийтийн ашиг сонирхолд үйлчилнэ гэсэн эрх зүйн үндэслэлээр энэ нь нийтийн мэдээлэл болох[19] ба хуулийн шинэ үндэслэл гаргалгүйгээр, мөн техникийн хувьд нарийн мэдээлэл хуваалцах механизм боловсруулалгүйгээр мэдээллийг ашиглах боломжийг Нэгдсэн Вант Улсын худалдан авалтын байгууллагад олгох юм. ЭӨ-н мэдээллийг төрийн бусад яам хэлтсүүд буруугаар ашиглана гэсэн болгоомжлол яригддаг. Жишээ нь Армен улсад ЭӨ-н мэдээллийг задлах замаар хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах, саад учруулахад ашиглаж байгаа талаар хэвлэл мэдээллийн компаниуд анхааруулж хэлсэн.[20] Энэ тохиолдолд олон нийтэд нээлттэй болгосноор мэдээлэл хэрхэн ашиглагдаж байгааг олон нийт хянах боломжтой болно гэсэн үг юм.

#### Нүд 2: Татварын бодлого боловсруулахад эцсийн өмчлөгчийн мэдээлэл ашиглагдах нь

Нэгдсэн Вант Улсын баялгийн татварт гаргасан саналуудад гүн гүнзгий дүн шинжилгээ хийх зорилгоор Нэгдсэн Вант Улсад Баялгийн Татварын Комиссийг 2020 оны эхээр байгуулсан байдаг. Уг комисс Нэгдсэн Вант Улсын баялгийн татвар зохистой, оновчтой эсэхийг судалсан бөгөөд баялгийн татварыг бүх талаас нь эдийн засагчид, хуульчид, нягтлан бодогчидтой хамтран судалжээ. Судлаачдын нэг нь ингэж хэлжээ, “[ЭӨ-н] мэдээлэл нь бодлого боловсруулахад маш чухал үүрэгтэй. Баялгийн Татварын Комиссын зүгээс эдгээр мэдээллийг ашиглан Нэгдсэн Вант Улс дахь татвар ноогдуулж болох дээд баялгийг хэмждэг.”[21] Уг тайлангаар өөр өөр төрлийн баялгийн татварын ашиг тус, хэрэгжих боломж болоод баялгийн татвар хэр их хөрөнгийг төсөвт төвлөрүүлж болох талаарх загвар, тооцооны талаар засгийн газруудад зөвлөмж өгчээ.[22]

## Хувийн хэвшлийн хэрэглэгчид

### Үүрэг хүлээсэн байгууллагууд

Хаалттай төв бүртгэлтэй дэглэмийн хүрээнд санхүүгийн байгууллага (СБ) зэрэг үүрэг хүлээсэн байгууллагууд болон харилцагчаа мэдэх (ХМ) хуульд захирагддаг Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын (СББМҮҮ) хувьд ЭӨ-н мэдээлэлд нэвтрэх боломжтой байдаг.[b] Гэвч хаалттай бүртгэлтэй дэглэмийн хүрээнд бүх орон СБ болон СББМҮҮ-д мэдээлэлд нэвтрэх эрхийг олгодоггүй[c] ба олгодог оронд ЭӨ-н мэдээлэлд гадаадаас нэвтрэх нь их

b Жишээлбэл, СБ болон СББМҮҮ-д хандах эрх нь МУЭТЗ-ийн дагуу заалт юм.

c Жишээлбэл, Ази, Африк, Ойрхи Дорнод, Латин Америкийн чиг хандлага нь төрийн бус байгууллагын хүртээмжийг хязгаарлаж байх шиг байна.

бэрхшээлтэй байсаар байна. Иймд систем төгс болох хүртэл нийтийн бүртгэл нь хаалттай бүртгэлээс илүү үүрэг хүлээсэн байгууллагуудад нэвтрэх боломжийг илүү олгож байна.

## Үүрэг хүлээгээгүй байгууллагууд

ЭӨ-н мэдээлэл нь үүрэг хүлээсэн байгууллагуудад хэрэг болохоос гадна хэнтэй бизнес хийж байгааг нь мэдүүлэх боломжоор хангах замаар ямар ч компанид эрсдэлээ удирдахад тус болдог. 2016 онд, захирлуудаас судалгаа авахад 91% нь бизнес хийж буй компаний ЭӨ-н мэдээллийг чухал гэж хариулжээ.[23] Ханган нийлүүлэлтийн сүлжээний дарга нараас судалгаа авахад 84% нь ханган нийлүүлэлтийн сүлжээний ил тод бус байдал хамгийн их бэрхшээл дагуулдаг гэж хариулсан бөгөөд "дийлэнхи компаниуд харанхуй болон бүтэцгүй мэдээллийн 80%-г хардаггүй" гэжээ.[24] Жишээ нь хуурамч бараа, өмчлөгч нь үл мэдэгдэх компаниудын дагуулах санхүүгийн болон нэр хүндийн эрсдэлийг[25] бууруулахад ханган нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдал буюу сүлжээн дэх компаниудын ЭӨ нь чухал юм.[26]

Зарим компани одоогийн байдлаар энэхүү мэдээллийг худалдан авч байгаа боловч мэдээллийн цар хүрээ, чанарт асуудал байгаа гэжээ.[27] Үүнээс гадна эдгээр зардал нь жижиг компаниудын хувьд илүү өндөр тусдаг.[28] ЭӨ-н мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосноор бүх компанид нэг ижил мэдээлэл авах боломжийг олгон судалгаа хийх зардлыг багасгаж эрсдэлийг бууруулна. Ингэснээр өрсөлдөөний талбарыг тэнцвэржүүлж[29] МУЭТЗ-д дурдсанчлан "бизнесийн гүйлгээ, санхүүгийн тогтолцоон дахь итгэлцлийг хадгална," (Нүд 10-г үз).

### Нүд 3: Нэгдсэн Вант Улсад нийтэд нээлттэй эцсийн өмчлөгчийн мэдээллийг компаниуд ашиглах нь

Нэгдсэн Вант Улсын ЭӨ-н бүртгэлийг хянаж үзэхэд бизнесүүдийн голчлон хайсан зүйлс нь "харилцагчдын талаарх мэдээлэл (64%) байсан ба өмчлөлийн энгийн бүтэцтэй бизнесүүд өмчлөлийн нарийн бүтэцтэй бизнесүүдтэй харьцуулахад ийм мэдээллийг хайх магадлал өндөр байжээ (65%)".[30] Судалгаанд хамрагдсан бизнесүүдийн 64% нь авсан мэдээллийг хэрэгтэй болон маш хэрэгтэй гэжээ.[31]

Нийгмийн түвшинд илүү сайн мэдээллийг төлбөрөөр авах чадвартай том компаниуд болон нийтийн мэдээлэл ашигладаг жижиг компаниудын хоорондох мэдээллийн тэнцвэргүй байдлыг арилгаснаар зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж итгэлцэл, ил тод байдалд суурилсан бизнесийн соёлыг бүрдүүлэх боломжтой.[32] Ийм учраас компаниуд ЭӨ-н мэдээллийг нээлттэй болгохыг засгийн газраас шаардах нь нэмэгдэж байгаа нь гайхах зүйл биш юм.[33] Үндэстэн дамнасан уурхай ВНР компаний Комплаенс хариуцсан захирал Крис Робинсоны хэлсэнээр: "Нийтийн ЭӨ-н бүртгэл нь авлигын эсрэг хамгийн үр дүнтэй хэрэгсэл. [Нийтийн бүртгэл] нь мэдээллийг төр хадгалж байснаас дээр. Энэ нь цэвэрхэн үйл ажиллагаа эрхлэх зорилготой, ёс зүйтэй компаниудын хувьд өрсөлдөөний талбарыг тэнцвэржүүлж авлигатай холбогдсон компаниудыг авлига авахад нь хэцүү болгодог. Энэ нь хөрөнгө оруулалтын орчин болон аливаа улсад хөрөнгө оруулалт хийх итгэлийг сайжруулдаг. Компаний хувьд ВНР нь өөрийн харьцдаг компани болон ханган нийлүүлэгчдийнхээ талаарх эцсийн өмчлөгчийн мэдээллийг хайдаг. Үүнийг баталгаажуулахад хүндрэлтэй байх нь олонтаа. Мэдээллийг нийтэд нээлттэй болгосноор баталгаажуулалт хийх арга замыг нэмэгдүүлнэ. ВНР-н хувьд ханган нийлүүлэгчдээ танихад хялбар болно.[34]

ЭӨ-н мэдээллийг ашиглах нь байгаль орчин, нийгмийн засаглалын (БОНЗ) хамгийн үр дүнтэй арга туршлага гэдгийг илүү ихээр хүлээн зөвшөөрсөөр байна.[35] Давос 2021 чуулган дээр Дэлхийн Эдийн Засгийн Форумаас ЭӨ-н мэдээллийг компаний гуравдагч талууд, нийлүүлэгчдийн үйл ажиллагаа болон тэдний үйлдэж буй байгаль орчин, нийгэмд хор хохиролтой үйлдлүүдийг хянахад зайлшгүй шаардлагатай гэж дүгнэсэн байна.[36] "нэмэгдэж буй баримт, хөдөлгөөн, зохицуулалтаас болоод" компаниуд шууд хариуцлага хүлээхгүй хэдий ч БОНЗ-н зарчмууд нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад илүү чухал хүчин зүйл болж байна.[37] Олон улсын хөрөнгө оруулалтын компаний Тогтвортой байдлын Даргын хэлсэнээр "үйлдвэрлэлийн үйл явц эсвэл ханган нийлүүлэлтийн сүлжээний талаар итгэлтэй биш байвал шалтгаан байж таарна. Эрс ил тод байдлын энэ цаг үед өөрийн бүтээгдэхүүн, арга туршлага, үнэ цэнийн сүлжээгээ хар."[38]

## Эцсийн өмчлөгчийн мэдээлэл олгогч, дахин хэрэглэгчид

Хувийн гуравдагч ЭӨ-н мэдээлэл олгогч нь ЭӨ-н мэдээллийн олон нийтэд нээлттэй болгохыг засгийн газраасаа шаардах нь нэмэгдсээр байна.[39] ЭӨ-н мэдээлэл олгогчид нь төрийн бүртгэлээс ЭӨ-н мэдээллээ голчлон авдаг. Тэд мэдээллийг дижитал, машин уншиж болох форматанд оруулан стандартжуулж бүтэцтэй мэдээлэл болгох үйлчилгээ үзүүлдэг. Мэдээллийг цэвэрлэн алдаа гарсан эсвэл

(тухайн талбарт буруу бичилт хийгдсэн зэрэг) хуучирсан байж болох хэсгүүдийг тэмдэглэж өгдөг. Илүү нарийн үйлчилгээгээрээ мэдээллийг өөр систем, засгийн газрын бүртгэл, болон олон нийтэд нээлттэй бусад мэдээлэлтэй харьцуулан, зардал ихтэй нээлттэй эх сурвалжтай судалгаагаар дамжуулан мэдээллийг нэмэгдүүлдэг.[40] Товчхондоо ЭӨ-н мэдээлэл олгогчид нь зарим ЭӨИТБ-тай дэглэмтэй засгийн газрын хийж буй мэдээллийг баталгаажуулж илүү бүтэцтэй болгох зэрэг үйлчилгээг хийдэг. Засгийн газрууд нь олон нийтэд нээлттэй бус нэмэлт эх сурвалжуудыг ашиглан ЭӨ-н мэдээллийг баталгаажуулж чадах тул мэдээллийг баталгаажуулах илүү боломжтой байдаг. Харамсалтай нь биеийн байцаалт, бүртгэлийн шаардлагаас эхлээд төлбөр хураамж авах зэргээр олон засгийн газрууд мэдээлэлд нэвтрэхэд саад тавьж ЭӨ-н мэдээлэл олгогчдод мэдээлэл авч өргөжүүлэхэд нь хүндрэл учруулдаг.[41]

### Нүд 4: YouControl: Украйнд эцсийн өмчлөгчийн мэдээллийг дахин ашиглах нь

YouControl бол Украйн дахь бизнесийн ил тод байдлыг хангах зорилготой Украйны компани юм. Тус компани нь Украйны нийтэд нээлттэй ЭӨ-н бүртгэл Улсын Нэгдсэн Бүртгэлээс мэдээлэл авч Украйны бизнесийн салбар дахь авлигыг бууруулж ажилладаг. YouControl нь “нийцэл, зах зээлийн дүн шинжилгээ, бизнесийн мэдээ мэдээлэл, эрэн сурвалжлах ажлын аналитик систем”-г боловсруулжээ. ЭӨ-н Улсын Нэгдсэн Бүртгэл зэрэг 87 засгийн газрын бүртгэлээс мэдээлэл авахаас гадна өөрийн хийсэн шинжилгээг ашиглан төлөгдөөгүй татвар, хүлээгдэж буй шүүх ажиллагаа, татварын тайлан өгөөгүй зэрэг болгоомжлууштай зүйлсийг агуулсан их хэмжээний мэдээллийг компани дээр гаргаж өгдөг.[42] YouControl хувийн хэвшилд төлбөртэйгөөр үйлчилгээ үзүүлдэг боловч төрийн бус байгууллага (ТББ), иргэний нийгмийн байгууллага (ИНБ), их сургуулиудад мэдээллийг үнэ төлбөргүй олгодог.

YouControl нь вебсайт дээрээ мэдээллийг нээлттэй нийтэлсэн нь Украйнд шударга бус бизнес, залилантай тэмцэхэд их хэрэг болж байна.[43] Вебсайт дээрх хэд хэдэн судалгаа нь YouControl-г ашиглан бизнес хийхээс өмнө залилах үйл ажиллагаар тогтоон хэдэн зуун мянган доллар хэмнэсэн компаниудын жишээг өгнө.[44] Үүнээс гадна YouControl-н харилцагчид этгээд үйлдлүүдийг албаныханд мэдээлэх боломжтой ба баталгаажуулалт хийх ажлын хэсгийн хувиар төрд бүртгэлийн талаар санал зөвлөгөө өгдөг.

Баталгаажуулсан ЭӨ-н мэдээллийг төр олон нийтэд нээлттэй болгоход зах зээл бусниж ЭӨ-н мэдээлэл олгогчдыг мэдээлэл цэвэрлэх үйлчилгээнээс илүү үнэ цэнтэй үйлчилгээрүү хөтөлдөг. Энгийнээр хэлэхэд эдгээр компаниудын авч байгаа мэдээлэл илүү бүтэцтэй байх тусам нээлттэй эх үүсвэртэй судалгааны илүү нарийн төвөгтэй зүйлсийг хийх боломжтой болдог. ЭӨ-н мэдээллийн үйлчилгээ олгогчид нь ЭӨ-н мэдээлэлд илүү үнэ цэнэ нэмэх илүү нарийн хэрэгслүүдийг санал болгодог болж байна. Жишээ нь зарим нь хөрөнгө оруулагч эсвэл ЭӨ болон бусад этгээдүүдийн хоорондын харилцаа илүү сайн ойлгох сонирхолтой тогтвортой байдлын яам хэлтсүүд зэрэг анхдагч зохицуулалтын хэрэглэгчдээс гадуурх хувийн хэвшлийн тодорхой хэрэглэгчдэд илүү тохирсон үйлчилгээг санал болгодог.[45]

Нээлттэй компани болон ЭӨ-н мэдээлэл нь багагүй эдийн засгийн үнэ цэнэтэйг илтгэх баримтууд бий болсоор байна. PwC-н судалгаагаар харуулсанаар Итали улсад компаний өмчлөлийн мэдээлэл Италийн мэдээллийн салбарын эдийн засгийн 10%-г бүрдүүлдэг ажээ.[46] Европын Комисст зориулж хийсэн нөлөөллийн үнэлгээгээрээ Делойт дараах дүгнэлтэд хүрчээ: “Түүчээлж буй орнуудын туршлагаас харахад компаний мэдээлэл илүү нээлттэй болж байгаагаас үүдэн мэдээллийн үнэ цэнэ экспоненциал байдлаар өсч байгаа нь илт байгаа бөгөөд энэхүү урьдчилсан жишээ нь бусад орнуудад юу болж болохыг илтгэж байгаа гэдэгт эргэлзэх шалтгаангүй юм.[47]

### Нүд 5: Нэгдсэн Вант Улс дахь ЭӨ-н мэдээллийн эдийн засгийн үнэ цэнэ

Компаний Хэлтсийн (КХ) 2019 онд явуулсан судалгаагаар Нэгдсэн Вант Улсын компаний мэдээллийн үнэ цэнийг дахин хэрэглэгч тутамд дунджаар 1,100 фунт стерлинг гэж тооцсон бөгөөд жилд нийт 1 тэрбумаас 3 тэрбум фунт стерлингийн[48] ашиг өгдөг ба Компаний Хэлтсийн Үйлчилгээний хэрэглэгчдийн хэрэглэдэг ЭӨ-н мэдээлэл зөвхөн 40 саяаас 120 сая фунт стерлингийг[49] бүрдүүлдэг гэж гарчээ. Уг судалгаанд тайлбарласнаар “КХ-н мэдээллийн багц бүтээгдэхүүнд нэвтэрдэг жижиг зуучдын хагасаас илүү нь тухайн бүтээгдэхүүнийг үнэгүй

болсоных нь дараа нэвтэрч эхэлсэн байна. Энэ нь үнэгүй мэдээлэл бизнесийн шинэ боломжийг бүрдүүлж байгааг илтгэнэ.[50]

## Иргэний нийгэм

Шүгэл үлээгч, эрэн сурвалжлах сэтгүүлч, судлаач, олон нийтийг багтаадаг иргэний нийгэм нь нийтийн ЭӨ-н мэдээллийн гол хэрэглэгч бүлэг юм. Иргэний нийгмийн оролцогчид нийтэд нээлттэй мэдээлэл болон Панам, Парадайсын баримт, Луанда Лийк зэрэг задарсан мэдээг ашиглан авлига, санхүүгийн гэмт хэргүүдийг ил тод болгоход чухад үүрэг гүйцэтгэдэг. Жишээ нь хараат бус хэвлэл мэдээллийн төв, сэтгүүлчдийн дэлхийг хамарсан сүлжээний эрэн сурвалжлах сэтгүүл зүйн талбар болох Зохион Байгуулалттай Гэмт хэрэг, Авлигыг Мэдээлэх Төсөл (ЗБГХАМТ) нь 7.3 тэрбум ам.доллартай тэнцэх торгууль төлүүлж, хөрөнгө хураалгуулсан ба 500 гаруй баривчилгаа, ял оноолтод хүргэжээ.[51]

### Нүд 6: ЕХ дахь ашиг сонирхлын зөрчлийг илчлэхэд ашигласан нийтэд нээлттэй мэдээлэл[d]

2011 онд авлигын эсрэг мөрийн хөтөлбөрөөр[52] улс төрд орохын өмнө одоогийн Чехийн Ерөнхий сайд Андрей Бабис хувийн хэвшилд ажилладаг байсан ба 1993 онд Агроферт Групыг үүсгэн байгуулж байжээ. Өнөөдөр Агроферт нь *MF DNES* ба *Lidové noviny* гэх Чех улсын хамгийн том хоёр сонин болон Чехийн хамгийн их уншигддаг мэдээний сервер болох *iDnes*-г эзэмшдэг Мафра медиа групыг оролцуулаад 250 гаруй охин компанитай.[53]

Чехийн ашиг сонирхлын зөрчлийн хууль батлагдаж засгийн газрын гишүүн болон төрийн бусад албан тушаалтнуудыг хэвлэл мэдээлэлд удирдах хэмжээний хувь эзэмшдийг хориглодог болсоны дараа Бабис Агрферт Групын өмчлөлийг хоёр Траст сан руу шилжүүлжээ: 565 хувьцаа (89.97%) эзэмшдэг АВ хувийн Траст I; ба 63 хувьцаа (10.03%) эзэмшдэг АВ хувийн Траст II.[54] Агроферт нь одоогоор 4 тивийн 18 оронд үйл ажиллагаа[55] явуулдаг бөгөөд хөдөө аж ахуй, хүнс боловсруулалтын чиглэлээр өөрөө тэргүүлдэг Чех болон Словак улсад бүртгэлтэй.[56]

2018 онд Словакийн нийтийн ЭӨ-н бүртгэлд судалгаа хийсний дараа Бабис нь Агроферт Словакийн таван эцсийн өмчлөгчдийн нэг болохыг ТИ Словак илрүүлжээ.[57] Үүний хариуд Агрофертийн зүгээс ТИ нь хуулийг гуйвуулан тайлбарласан ба “Ноён Бабис нь Агроферт Групын Словак компаниудыг удирдагч этгээд биш” гэжээ.[58] Үүнийг ТИ Словак няцаан Бабисыг бусад эцсийн өмчлөгчид буюу трастигийн захирлуудаа халах эрх мэдэлтэй цорын ганц эцсийн өмчлөгч болох мэдэгдэв.[59] Үүнээс гадна тэрээр баталгаажуулсан задруулгын баримт бичигт ашиг хүртэгчээр бичигдсэн байдаг; төрийн албаа хашиж дуусахад нь хувьцаа түүнрүү буцаж очихоор трастын санг зохион байгуулжээ.[60] Мөн 2017 онд Бабисыг өмчлөлөө хоёр траструу шилжүүлэхийн өмнө болон дараа Агрофертийн охин компаниуд ЕХ-ны татаасыг авсан тул ЕХ-ны санхүүжилтийг[61] авах эрхгүй улс төрчдийн эзэмшлийн компанитай холбоотой ЕХ-ны хуулиудыг зөрчин Чехийн Ашиг Сонирхлын зөрчлийн Хуулийг зөрчсөн байж болзошгүй юм.

Саяхан хийгдсэн ЕХ-ны аудитаар дараах зүйлсийг илрүүлжээ: “Траст Сангийн зорилтуудыг Ноён Бабис [...] тодорхойлж [...] өөрөө халах эрхтэй бүх оролцогчдыг томилсоны хувьд тэрээр тус Траст Санд шууд болон шууд бус шийдвэрлэх нөлөөтэй гэж дүгнэх боломжтой. Энэ дүгнэлтэнд үндсэслэн, Комиссийн үйлчилгээ нь Ноён Бабисыг эдгээр Траст Сангуудаар дамжуулан АГРОФЕРТ бүлгийн толгой компанийг шууд бусаар удирддаг гэж үзэж байна [...]”. Түүнийг ЕХ-ны Ашиг Сонирхлын Зөрчлийн Хуулийг зөрчсөн болохыг тогтоожээ.[62]

Санхүүгийн эрэн сурвалжлах нэгжүүд болон бусад эрх бүхий байгууллагууд хангалттай санхүүждэг байсан бол мэдээлэл хуваалцах системүүд саадгүй ажиллан хууль зүйн систем үргэлж хараат бус, үр дүнтэй байж сэтгүүлчдийн санхүүгийн гэмт хэргийг эрэн сурвалжлах хэрэгцээ бага байх байсан. Гэвч сэтгүүлчдийн саяхан задалсан мэдээллээс харахад бодит байдал дээрх төсөөллөөс хол юм. АНУ-н Сангийн Яамны Санхүүгийн Гэмт Хэргийг Хянах Сүлжээгээр

d Бүрэн түүхийг үзнэ үү: Таймон Кипе, Виктор Понсфорд, Луиза Расселл-Привата нар “Бенефициар өмчлөлийн олон нийтийн бүртгэлийн эхний үр нөлөө: Словак”, Нээлттэй эзэмшил, 2020 оны 9-р сар, https://www.openownership.org/uploads/slovakia-impact-story.pdf.

нэрлэсэн FinCEN Баримтуудыг 2020 оны 9-р сарын 20-нд нийтэлсэн бөгөөд үүнд банкуудаас АНУ-н санхүүгийн эрэн сурвалжлах нэгжүүдэд өгсөн сэжигтэй үйл ажиллагааны мэдээллийг (СҮАМ) задалжээ. Уг баримтуудаар одоогийн олон улсын Мөнгө Угаахын эсрэг тогтолцоо дутагдлуудтай ба жишээ нь анхааруулж торгосоор байтал том Санхүүгийн байгууллагууд хууль бус мөнгийг зөөхөд үүрэг гүйцэтгэн АНУ-н Хууль Зүйн Яамны ажилтан, санхүүгийн гэмт хэргийн прокурор асны хэлсэнээр "шудгүй болсон систем" дотор үйл ажиллагаа явуулдаг нь ил болсон юм. ФАТФ-н гүйцэтгэх нарийн бичгийн дарга "Хэн бүхэн муу байна" гэж дүгнэсэн.[63] Санхүүгийн гэмт хэрэгтэй зөвхөн төр дангаараа тэмцэх ёстой гэж зарим нь үздэг.[64] Гэвч нөхцөл байдлыг авч үзэхэд төр энэхүү гол үүргээсээ чөлөөлөгдөх ёсгүй ч нийтийн бүртгэл нь эрэн сурвалжлах чухал үүргийг иргэний нийгэмд олгон санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн чиг үүрэгт олон нийтийн хяналтыг бий болгоно.

Өндөр орлоготой орны харьцангуй сайн санхүүжилт авдаг Санхүүгийн эрэн сурвалжлах нэгжүүд ч гэмт хэргийг зогсоож чадахгүй байгаа нь иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулж болох ба энэ нь дунд зэргийн санхүүжилттай оронд бүр илүү ажиглагдах магадлалтай. Нийтийн бүртгэл нь мөн төрд иргэдийн өмнө хариуцлага хүлээхэд дэм болох ба санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхээс гадна төрийн санхүүжилт, гэрээ, тусгай зөвшөөрлийг хэн авахыг мэдэх зэрэг бусад гол чиг үүргүүдэд олон нийт хяналт тавих боломжийг олгоно.[65] Ил тод байдал нь тодорхой нөхцөлд төрийг илүү сайн ажиллуулж хариуцлага, итгэлцлийг нэмэгдүүлдэг болохыг судалгаа илтгэж байна.[66] Хариуцлага нь нийтийн ЭӨ-н мэдээллийн хэрэглээний чухал зорилго юм. Дээр дурдсанчлан олон орнууд төрийн худалдан авалтад ЭӨИТБ-г бий болгохоор хөөцөлдөж байна; төрийн санхүүжилт авагчдын ЭӨ-н мэдээллийг нийтлэхээс гадна гэрээ, зарлагын мэдээллийг ил болгосноор ялангуяа гэнэтийн арга хэмжээнд татвар төлөгчдийн мөнгийг,[67] төр зарцуулахдаа хариуцлагатай байх боломжийг олгоно.[68]

### Нуд 7: Бейрутын дэлбэрэлтийг эрэн сурвалжлах нь

2020 оны 8-р сарын 4-ний өдөр Бейрутын боомтны агуулахад дэлбэрэлт болж 211 хүн[69] нас барж 5,000 хүн бэртэж гэмтэн 300,000 гаруй хүн түр нүүлгэн шилжүүлэгдэж 10-15 тэрбум ам.долларын хохирол учирсан байдаг.[70] Дэлбэрэлт нь Бейрутын боомтны агуулахад аюултай нөхцөлд хадгалагдаж байсан 2,750 тонн аммонийн нитрат тэсэрсэнээс үүдсэн байна.

Уг аммонийн нитрат 2013 оны 9-р сарын 23-ны өдөр Гүржийн Батумийгаас Мозамбикийн Бейраруу явж байсан Молдавийн далбаатай МВ Росус хөлөг онгоцоор Бейрутад ирсэн юм.[71] Уг хөлөг онгоц нь Бейрутын Боомтын албаныхан үзлэг хийсний дараа техникийн асуудалтай тулгарсанаар Бейрутад зогсох шаардлагатай болжээ.[72] Аммонийн нитратаар тэсрэх бөмбөг[73] хийдэг учраас уг бодисыг илгээх болсон шалтгааны талаар янз бүрийн таамаглал гарсан ба энэхүү Бейрутын гай барцдын үйлдэгчид, тэдний зорилгын талаар мөрдөн шалгалт хийгджээ.[74]

Санхүүгийн гэмт хэрэг эрэн сурвалжлагч Грам Барров, Рэй Блэйк нар Дэлхийн Нэйлттэй Өмчлөлийн Бүртгэл дэхь Англи, Украйны дата мэдээг ашиглан мэдээлэл цуглуулж Молдавын хөлөг онгоцын өмчлөгчийг Английн халхавч компаниудын компаниудын сүлжээний удирдлага болохыг хөөн илрүүлэв. Тэд эрэн сурвалжлагаараа Бейрутад зогссон хөлөг онгоц болон Англид бүртгэлтэй компани хоёрын хоорондох шууд холбоог олсон ба тус компаний эцсийн өмчлөгч нь Англи, Украйнд бүртгэлтэй бусад компаниуд болон хэд хэдэн хувь хүн, компаниуд, хоригтой холбоотой болохыг илрүүлжээ.[e]

Барров, Блэйк нар энэ талаар товч хэлэхдээ: Бейрутад тэсэрсэн аюултай химийн бодисуудыг худалдан авахад оролцсон Английн компаниудын сүлжээ байгаа бөгөөд дэлхий даяар хориг тавьсан хүмүүсийн эзэмшлийн эсвэл удирдлагын доорх

e Бүрэн түүхийг үзнэ үү: Чинве Экене Эзеигбо, Таймон Кипе, Луиза Рассел-Привата, "Эцсийн өмчлөлийн олон нийтийн бүртгэлийн эхэн үеийн нөлөө: Их Британи", Нээлттэй эзэмшил, 2021 оны 4-р сар, https://www.openownership.org/uploads/OO%20Impact%20Story%20UK.pdf.

эдгээр компаниуд нь “Исламын Улс”-н өмнөөс газрын тосны худалдаанд оролцсон байж магадгүй гэж үзэж байгаа юм.

“Энэ түүхийг олон нийтэд гарган ирж гэрэл тусгах боломжтой болсон цорын ганц шалтгаан нь Англи улс зуун хувь нээлттэй, нэвтрэх боломжтой, компаний болон ЭӨ-н бүртгэл ажиллуулдагт байгаа юм.”[75]

## Баталгаажуулалт

Хаалттай бүртгэл нээлттэй бүртгэлтэй харьцуулахад илүү чанартай мэдээлэл агуулдаг гэж зарим нь үздэг.[76] Ингэж ярьж байгаа нь ЭӨ-н мэдээллийн чанар нь баталгаажуулалтын цогц механизмтай байхаас шалтгаалдгийг ойлгоогүйтэй холбоотой. Дараагийн удаа хэн нэвтрэх вэ гэдэг нь гол асуудал биш. Үнэндээ бол ЭӨ-н бүртгэлийг нээлттэй, нийтийн болгох нь ЭӨ-н мэдээллийг баталгаажуулахад тус болох техник их шаардагдахгүй, дэм болох механизм юм. Бүртгэлийг нийтийн болгосноор санамсаргүй алдаа болон зориуд оруулсан хуурамч мэдээллийг хувийн хэвшил, иргэний нийгэм, олон нийтээр шалгуулах боломжийг бүрдүүлнэ.[77] Буруу зөрүү мэдээллийг хүлээн авч засах механизм байгаа тохиолдолд мэдээллийг олон нийтэд нээлттэй нийтэлсэнээр мэдээллийн хэрэглээг өсгөн цаашлаад буруу зөрүү мэдээллийг олж илрүүлэх боломжийг нэмэгдүүлэн мэдээллийн чанарыг сайжруулах боломжтойг судалгаа харуулдаг.[78] Бүртгэлийг баталгаажуулах арга зам нь зөвхөн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох байж болохгүй ба мэдээллийг оруулах үед болон дараа нь шалгадаг байх хэрэгтэй.[79]

### Нуд 8: Нэгдсэн Вант Улс иргэний нийгмийн мэдээллийг ашигласнаар мэдээллийн чанарыг сайжруулах шинэ нээлтүүд бий болдог.

Нэгдсэн Вант Улсын компаниудын эцсийн өмчлөгчдийн талаарх мэдээлэлд хийсэн хамгийн том шинжилгээний хүрээнд Global болон DataKind UK 2018 онд Компаний Хэлтсийн 10 сая гаруй компаний бүртгэлийг судалжээ.[80] Томоохон хяналтын эрхтэй этгээдүүдийн (ТХЭЭ) мэдээллийг улс төрч, компаний дарга нарын мэдээлэлтэй нийлүүлэн сэжигтэй, алдаатай мэдээллийг илрүүлэх алгоритмыг тэд боловсруулав. Шинжилгээгээр мянга мянган компани дүрэм журманд нийцэхээргүй сэжигтэй мэдээлэл оруулсан болохыг илрүүлжээ. Жинхэнэ өмчлөгчийг мэдэгдэхээс зайлсхийхийн тулд (оруулах ёсгүй) гадаад компанийг эцсийн өмчлөгчөөр нэрлэх, өмчлөлийн тойрог бүтэц үүсгэх зэрэг аргуудыг ашиглаж байсан байна. Энэ судалгаанд үндэслэн эрсдэл өндөртэй мэдээллийг илрүүлж цааш шалгавал зүйтэй компаниудыг тогтоохын тулд шинжээчид анхааруулах системийг боловсруулсан байна.

Энэ судалгааны үр дүн нь Английн ЭӨ-н бүртгэлийн мэдээллийг сайжруулахыг иргэний нийгмийн зүгээс шаардах үндэслэл болсон бөгөөд Английн Засгийн газар дараа нь сайжруулах саналын талаар хийсэн олон нийтийн хэлэлцүүлэгтээ авахдаа тус судалгааг хэд хэдэн удаа иш татжээ.[81] Хэд хэдэн зөвлөмжүүдийг Английн Засгийн газрын санал болгосон шинэчлэлд оруулсан ажээ.[82]

Английн Засгийн газар энэ судалгааг өөрөө бие даан хийж болох байсан ч олон нийтэд мэдээллийг машинаар унших боломжтой форматаар нээлттэй болгож өгсөнөөр иргэний нийгмийн дата өгөгдөл судлаачдад сул тал, цоорхойг түргэн шуурхай илрүүлэн бодлого гаргагчдад баримтад үндэслэсэн шийдлүүдийг санал болгож мэдээллийн чанарыг сайжруулах баталгаажуулалтын механизмыг бүрдүүлэх боломжийг бий болгосон юм.

### Урьдчилан сэргийлэх

Урьдчилан сэргийлэх үр нөлөөг хэмжихэд хэцүү учраас ил тод байдал болон хуулийн этгээдүүдийг буруугаар ашиглахаас сэргийлэх хоёрын хоорондох хамаарлыг тогтооход хэцүү юм. Гэхдээ мэдээллийг нийтлэх нь зарим нөхцөлд зан үйлийн өөрчлөлтийг бий болгодгийг баталсан баримтууд бий.[83] Мэдээллийг нийтлэх нь зохисгүй үйлдлээс сэргийлдгийг илтгэсэн Англи улсад ажиглагдсан баримтууд бий (Нүд 9-г үз).

#### Нүд 9: Ил тод байдал ба сэргийлэх: Шотландын Хязгаарлагдмал Түншлэлүүд

Шотландад санхүүгийн болон бусад мэдээллийг бүртгүүлэх шаардлага хязгаарлагдмал байдаг учраас Шотландын Хязгаарлагдмал Түншлэлийг (ШХТ) мөнгө угаагчдын хувьд зугтах машин гэж үздэг.[84] Англид ЭӨ-н нийтийн бүртгэлийг 2016 онд бий болгоход ШХТ нь мэдээлэл бүртгүүлэх шаардлагаас чөлөөлөгдсөн цөөн тоон аж ахуйн нэгжийн хэлбэрүүдийн нэг байв. ШХТ-р хууль ёсны үйл ажиллагаа явуулдаг ч 2015-с 2016 оны хооронд ЭӨИТБ-г хэрэгжүүлж эхлэхтэй зэрэгцэн тоо нь бараг хоёр дахин нэмэгдсэн гэж Global Witness-н дүн шинжилгээгээр гарсан бөгөөд энэ нь ШХТ-г ил тод байдлаас зайлсхийх зорилгоор ашиглаж байж магадгүй гэсэн болгоомжийг төрүүлсэн юм.

ШХТ-г ашиглан 4 жилийн хугацаанд Russian Laundromat гэх дэлхийн хамгийн том, өндөр зохион байгуулалттай мөнгө угаах ажиллагааны хүрээнд хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан улсуудаас 4 тэрбур фунт стерлингийг гаргасан болохыг эрэн сурвалжлах сэтгүүлчид илрүүлсэнээр энэ болгоомжлол бүр нэмэгдсэн.[85] Үүнээс гадна 2007-с 2016 оны хооронд байгуулагдсан ШХТ-н 70% нь 10 хаягт бүртгэгдсэн байсан ба 2014 онд 20 ШХТ-г ашиглан Молдавын банкнуудаас[86] 1 тэрбум гаруй ам.долларыг гаргасан гэсэн мэдээ байдаг.

2017 оны 6-р сард, Английн Засгийн газар ШХТ-үүдийг ЭӨИТБ-н дэглэмд оруулан өмчлөгчдөд нь Томоохон хяналтын эрхтэй этгээдүүдийн (ТХЭЭ) мэдээллийг Компаний Хэлтэст бүртгүүлэх шаардлага тавьсан.[87] "Ингэсэн даруй ийм хэлбэрийн компани үүсгэн байгуулагдах нь 7 жил дэх хамгийн доод түвшин хүртэл унасан буюу 2017 оны сүүлийн улирлын үзүүлэлт 2015 оны эцсийн оргил үеэс 80%-иар бага байсан" гэж Global Witness тэмдэглэжээ.[88]

ШХТ-н хэрэглээ энэхүү огцом өөрчлөгдсөн нь Английн ЭӨИТБ-н дэглэмд орсонтой маш тодорхой давхцаж байгаа явдал нь ЭӨ-н мэдээллийн олон нийтэд нээлттэй болгох нь зохисгүй үйлдлээс сэргийлэх эерэг нөлөөтэй болохыг илтгэж байна. Энэхүү дүн шинжилгээ нь харилцан хамаарал байгааг олсон ба бусад хүчин зүйлсийн нөлөө байгааг үгүйсгэхгүй ч компанийг хэрэгсэл болгон ашигладаг хүмүүсийн зан үйлд ЭӨИТБ нь өөрчлөлт оруулж байгааг харуулсан анхны баримт болж байна.[f]

**Улирал тутмын ШХТ үүсгэн байгуулалт**




Эх сурвалж: Global Witness (2018), Английн компаниудын жинхэнэ өмчлөгчдийн Бүртгэл 3 янзаар өгөөжөө өгч байгаа жишээ.[89]

[f] Бүрэн түүхийг үзнэ үү: Ezeigbo, Kiepe болон Russell-Prywata, "Эрт үеийн нөлөө: Их Британи".

# Хэрэгжүүлэгчдийн хувьд анхаарах асуудлууд

Хэрэгжүүлэгчдийн хувьд ЭӨ-н мэдээллийг хэзээ, ямар үндэслэлээр нээлттэй болгох вэ гэдгийг шийдэхдээ бодолцох хэд хэдэн зүйлс бий. Бодолцож үзэх хамгийн чухал зүйлс бол:

1. Мэдээллийг **төвлөрсөн бүртгэлд** нэгтгэн оруулах;
2. Мэдээллийг саадгүй **нэвтрэх, хэрэглэх боломжтой** болгох;
3. **хувийн нууц, мэдээлэл хамгаалалтын хуулийн дагуу** нийтлэх тухай эрх зүйн үндэслэл, өргөн хүрээг хамарсан зорилгыг тогтоох.
4. нийтэлсэнээс **бий болж болох хор уршгийг бууруулах** систем бий болгох.

## Төвлөрсөн бүртгэл

ЭӨ-н мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох урьдчилсан нөхцөл нь төвлөрсөн бүртгэлд нэгтгэн оруулсан байх явдал юм. Төв бүртгэлтэй байснаар мэдээллийг стандарт форматаар төвлөрсөн нэг байршлаас авах боломжтой болно. Энэ нь ЭӨ-н мэдээллийг бүх хэрэглэгч бүлэг үр дүнтэй ашиглах суурь нөхцөл болох ба ЭӨ-н мэдээлэлд нэвтрэх, шинжилгээ хийх ажиллагааны болон зардлын зарим саадуудыг арилгах юм. Төв бүртгэл нь ЭӨ-н мэдээллийг үр дүнтэй ил болгох Open Ownership Зарчмуудын (OO Зарчмууд) нэг бөгөөд чанартай, найдвартай мэдээллийг бүрдүүлэн мэдээллийг хэрэглэгдэх боломжийг нэмэгдүүлж цоорхойг бууруулдаг.[90]

ЭӨ-н мэдээллийн төв бүртгэлтэй байх нь ФАТФ-н хамгийн сайн туршлага гэж тодорхойлсон гурван нэмэлт аргуудын нэг юм.[91] ФАТФ-н улс орны үнэлгээг шинжилж үзэхэд төв бүртгэл мөнгө угаах эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой нь тодорхой харагддаг: ЭӨ-н мэдээллийг компани болон бусад институтууд хадгалдаг бусад төвлөрсөн бус аарга барилд суурилдаг улс орнуудтай харьцуулахад төвлөрсөн бүртгэл хэрэгжүүлдэг орнууд нь компаниудын ЭӨ-н мэдээллийг хангалттай, оновчтой, шинэчилсэн байдлаар түргэн шуурхай олгох ёстой гэсэн ФАТФ-н шаардлагыг илүү сайн хангадаг.[92] Төвлөрсөн бүртгэлийг хэрэгжүүлэх нь холбооны улсуудын хувьд илүү бэрхшээлтэй байж болох ба ФАТФ-н шаардлагыг хангахын тулд ЭӨ-н хуулийг нутаг дэвсгэрийн дэд нэгжүүд даяар нийцүүлэх шаардлага үүсч болно. 2008 онд үндэсний компаний бүртгэлийг бий болгохоос өмнө ямарваа нэг компаний мэдээллийг хадгалж байгаа эсэхийг тодруулахын тулд тус тусдаа өөр компани үүсгэн байгуулахад тус тусдаа өөр шаардлага тавьдаг Бразилын 27 муж бүртэй холбогдох шаардлагатай болдог байсан нь үүний хэр чухал болохыг харуулна.[93]

2016 онд төвлөрсөн болон нийтийн бүртгэлийг хэрэгжүүлж эхэлсэн Нэгдсэн Вант Улс дахь хууль сахиулах байгууллага “бүртгэлийг хэрэгжүүлж эхэлсэнээр мэдээлэл авахад түргэн, хялбар болсон гэж үзсэн”.[94] 2002 оны Английн засгийн газрын судалгаагаар төвлөрсөн ЭӨ-н бүртгэлтэй байснаар жилд 30 сая фунт стерлингийн цагдаагийн ажлын цагийн зардал хэмнэсэн гэсэн тооцоо гарсан; мөн хулгайлагдсан хөрөнгийг мөрдөн олж авахад хялбар болж бусад шууд болон шууд бус зардлын хэмнэлтүүдээс гадна бодит үр ашгаа өгч эхэлжээ.[95] Олон орнууд ЭӨ-н мэдээллийг гаргаж өгдөг компанийн бүртгэлээ төвлөрсөн болгож бизнес хийх үйл явцыг сайжруулж байна.

Төвлөрсөн бүртгэлийн давуу талыг өргөнөөр хүлээн зөвшөөрдөг. Тусгайлан заасан хуулийн этгээдүүдийн төвлөрсөн ЭӨ-н бүртгэлийг хэрэгжүүлэх багагүй ажлуудыг саяхнаас АНУ, Канадад хийж байна. АНУ-д 2020 оны Үндэсний Батлан Хамгаалахын Төсвийн Хуулийн хүрээнд Компаний Ил Тод Байдлын Хуулинд (КИТБХ) заалтууд оруулсан. КИТБХ нь FinCEN дотор ЭӨ-н бүртгэлийг бий болгох юм. Мужийн түвшинд хэд хэдэн мэдээлэл бүртгүүлэх дэглэм байсан ч АНУ үндэсний аюулгүй байдлын асуудлын хүрээнд үндэсний төвлөрсөн бүртгэлийг байгуулахаар болсон. АНУ-с ялгаатай нь 2021 онд төсөвлөгдсөн Канадын төвлөрсөн бүртгэл нь олон нийтэд нээлттэй байна.[96] Нигери улс удаан хугацаанд төлөвлөсний дараа төвлөрсөн бүртгэлийг хэрэгжүүлж байна. Анхны хувилбарыг 2021 оны эхээр хэрэгжүүлсэн ч багагүй сорилт бэрхшээлтэй

тулгарсаар байна.[97] ЭӨИТБ-н дэглэмийг эдгээр оронд хэрэгжүүлсэн нь том, холбооны бүтэцтэй, өндөр болон бага орлоготой орнуудад хэрэгжүүлэх туршлага болох юм.

## Мэдээллийн хүртээмж, хэрэглээ

Хэд хэдэн орон дээр дурдсан ашиг тусыг хүртэхийн тулд нийтийн ЭӨ-н бүртгэлийг хэрэгжүүлж эхэлсэн боловч олонхи нь дараах байдлаар хүртээмжийн хязгаарлалт тавьсан: мэдээлэлд төлбөр авах (жишээ нь Гана[98]); бүртгүүлэхийг шаардах (жишээ нь Болгар[99]), биеийн байцаалт шаардах (жишээ нь Герман[100]); хязгаарлалттай зөвшөөрөл өгөх (Жишээ нь Австри[101]). Зарим дэглэм компани нэр, дугаараар хайх боломжийг хязгаарлах зэргээр бусад саадуудыг тавьсан байдаг.[102] Ийм саадууд нь ЭӨ-н мэдээллийн ашиглан хүссэн бодлогын зорилгод хүрэх боломжийг хязгаарлана.

Ялангуяа, хүсэлт болгонд бага ч бай хураамж авах нь сэтгүүлчид, судлаачид, ТББ-уудыг мэдээлэлд нэвтрэхэд саатуулдаг. Энэ нь санхүүгийн гэмт хэргийн эрэн сурвалжлах зэрэг дээр дурдсан гарч болох ашиг тусыг үгүй болгодог.[103] Санхүүгийн эрэн сурвалжлагч Рэй Блэйк, Грам Барров нар “бүртгэлд нэвтрэх хураамжийг төлөх чадваргүй байсан учраас [...] бусад олон судалгааны төслүүдийг [хэрэгжүүлж чадаагүй]” ажээ.[104] Английд төлбөр авахаа больсоны дараа бүртгэл дээрээс хайлт хийх хүсэлтийн тоо 2014/2015 онд 6 сая байсан бол 2015/2016 онд 1.3 тэрбум, 2016/2017 онд 2.1 тэрбум болж 200 дахин нэмэгджээ.[105] Энэ нь ашиг тус өгч байгаа нотолгоо болохгүй ч мэдээллийн чанарыг сайжруулах зэрэг дээр дурдсан ашиг тусууд нь мэдээллийн хэрэглээтэй холбоотой байдаг.

Үүний адил зөвшөөрөл нь нийтийн ЭӨ-н бүртгэлийн ашиг тусыг ихээр хязгаарладаг. Нийтийн ЭӨ-н бүртгэлийн ашиг тусыг бүрэн гаргахын тулд хэрэглэгчид нь нийтийн мэдэлд буй мэдээллийг бизнесийн болон бизнесийн бус зорилгоор, үнэгүй хуулах, нийтлэх, түгээх, ашиглах боломжтой байх ёстой. Төр тусгайлсан зөвшөөрөл гаргах нь ихэссэн ба энэ нь хэрэглэгчдэд том бэрхшээлийг учруулж байна: зөвшөөрөл бүр нь хэрэглэгч мэдэх ёстой тодорхой хуулийн зохицуулалттай байх ба зөвшөөрлүүд нь хоорондоо нийцэхгүй байх асуудлууд гарч болно.[106] Иймд Нийтийн Мэдлийн Зориулалтын Зөвшөөрөл зэрэг Нээлттэй тодорхойлолттой нийцлийн зөвшөөрөл ашиглах нь зүйтэй ба энэ нь хэн бүхэнд ямар ч зорилгоор хамаагүй мэдээллийг чөлөөтэй ашиглах, өөрчлөх, хуваалцах боломжийг олгодог.[107]

Товчхондоо мэдээллийг бүтэцтэй, нээлттэй мэдээлэл болгох ёстой: төлбөр, биеийн байцаалт, бүртгэлийн шаардлага, бүртгэл ашиглагчийн талаар мэдээлэл цуглуулах эсвэл хязгаарлалт бүхий зөвшөөрөл олгох зэрэг босгогүйгээр нэвтэрч ашиглах боломжтой байх ёстой. Компани болон эцсийн өмчлөгчийн нэрээр хайх боломжтой байх ёстой. Эдгээр асуудлыг ОО-н зарчимд танилцуулсан.[108]

**Хүснэгт 1.** ЕХ-нд эцсийн өмчлөгчийн мэдээлэлд нэвтрэх болон хэрэглэхэд саад болдог зүйлс

| ВО-ын мэдээлэл | Тийм (улсын тоо) | Үгүй[g] (улсын тоо) |
|---|---|---|
| нээлттэй лицензийн дагуу лицензтэй (үндсэн мэдээллийн хувьд) | 8 | 19 |
| бүртгэлгүйгээр нэвтрэх боломжтой | 10 | 17 |
| үнэ төлбөргүй нэвтрэх боломжтой | 11 | 16 |
| програмчлалын интерфейс (API) хандалттай | 12 | 15 |
| бөөнөөр нь татаж авах боломжтой | 13 | 14 |
| машин унших боломжтой | 18 | 9 |
| ВО болон хуулийн этгээдийн аль алинд нь хайх боломжтой | 5 | 22 |

Эх сурвалж: Зөвшөөрөл, АПИ (Аппликейшн програмчлалын интерфейс), их хэмжээгээр татах, машин унших боломж: Делойт[109]; Бүртгэл, зардал, хайх боломж: Транспэрэнси Интернэшнл.[110]

g Үүнд хараахан хэрэгжээгүй эсвэл мэдээлэл байхгүй байсан улс орнууд багтана.

## Зардал

Нэвтрэхэд хураамж авч байгаагаа ЭӨ-н бүртгэлийн зардлыг нөхөн олох зорилгоор гэж тайлбарладаг. Энэ нь мэдээлэл бүртгүүлэхэд хураамж авах зэрэг зардлыг нөхөн олох хэд хэдэн аргуудын зөвхөн нэг нь юм. Дэлхий нийтийн, нийтийн ЭӨ-н бүртгэлд хийгдсэн зардлын цогц шинжилгээ байхгүй ч Делойт ЭӨ-н мэдээлэл зэрэг компаний бүртгэлийн зардлын талаар ЕХ-ны гишүүн орнуудад судалгаа явуулсан байдаг. Судалгаа нь дараах дүгнэлтэд хүрчээ: “Эдгээр мэдээллийг нээлттэй болгохтой холбоотой зардал, ашиг тусыг харьцуулахад нийгэм болон дахин хэрэглэгчдэд үзүүлэх ашиг тус нь мэдээлэл эзэмшигчдийн хүлээх зардлаас хамаагүй өндөр байгаа нь тодорхой болдог.[111]

АПИ суурилуулах нэг удаагийн зардал нь дунджаар 50,000 Евро гэсэн тооцоотой. Үүнээс гадна нийт бүртгэлүүдийг ажиллуулах жилийн зардал нь 3.2 саяаас 16 сая Еврогийн хооронд байх тооцоо бий.[112] Бусад ашиг тусуудыг түр хойш нь тавьлаа гэхэд эдгээр тоон үзүүлэлт нь дээр танилцуулсан мэдээллийг дахин ашиглахаас гарч болох эдийн засгийн үнэ цэнэнээс хавьгүй бага юм. Мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоход гарна гэж үздэг хамгийн том зардал бол мэдээлэлд хураамж авдаг орнуудын хувьд тус хураамжийг алдах юм. ЕХ-нд байрладаг эдгээр орнуудын зарим нь бүртгэлийг ажиллуулах зардлаас мэдэгдэхүйц илүү орлого олдог ч энэ нь мэдээллийг дахин ашигласнаас гарч болох эдийн засгийн үнэ цэнэнээс бага юм.[113]

Хэрэв хэрэгжүүлэгчид зардлыг бүртгэлээс шууд нөхөж олохыг хүсч байгаа бол бүх зардлын биш ч нилээдгүй хэсгийг мэдээлэл бүртгүүлэх хураамжаар олж болох ба энэ нь бизнес хийхэд хүндрэл учруулахгүй юм. Жишээлбэл Англи дахь Компаний Хэлтэс нь “зардлыг нөхөх зарчмаар үйл ажиллагаа явуулдаг ба хураамжаар дамжуулан нэг жилийг нөгөөгөөр нөхдөг.”[114] Зардлын дийлэнхийг компани үүсгэн байгуулах хураамжаар нөхдөг.[115] Эсрэгээрээ ЭӨ-н мэдээллийг ашиглахад үнэгүй бөгөөд энэ нь дээр дурдсан мэдээллийг дахин ашиглахаас гарах эдийн засгийн үнэ цэнийг бий болгодог. Ямартай ч Английг Дэлхий Банкнаас бизнес хийх хамгийн хялбар орнуудын нэгээр нэрлэдэг.[116]

Хэрэгжүүлэгчдэд тулгардаг бэрхшээлүүдийн нэг нь зардал гарсанаас өөр яам хэлтсүүд эдийн засгийн ашиг тусыг хүртдэг ба засгийн газрын төсөвлөлтөд үүнийг тооцох зохион байгуулалт байдаггүй. Үүнээс болоод зардлыг хүлээдэг байгууллагууд үйлчилгээ үзүүлэх үедээ хураамж авахаас өөр аргагүй болдог. Мэдээллийн бүтээгдэхүүний зардлыг дотоод төсвийн үйл явц болон яам хэлтэс хоорондын тодорхой гэрээ хэлэлцээрээр дамжуулан тооцохыг зорих хэрэгтэй. Эдгээр гэрээ хэлэлцээр нь урт хугацааны буюу жил бүр тооцоо хийхгүйн тулд жилийн төсөвлөлтөөс илүү цар хүрээтэй байх ёстой.

## Эрх зүйн үндэслэлийг тогтоох

Хувийн нууцыг хүний эрх гэж өргөнөөр хүлээн зөвшөөрдөг ч ихэнхи оронд энэ нь туйлын эрх байдаггүй. Зарим нөхцөлд, ялангуяа нийтийн ашиг сонирхлын төлөө буюу жишээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөхөд тус болгуулах замаар үүнийг хязгаарладаг. Мэдээллийн хамгаалалтын хуулиар хувийн нууцын эрхийг мэдээллийг хуулийн дагуу хэрэглэх эрхтэй тэнцвэржүүлэхийг зорьдог. Зарим тохиолдолд мэдээллийн хамгаалалтын хуульд мэдээллийг зарим байдлаар ашиглах нь хувийн нууцад халдах ч хууль зөрчсөнд тооцогдохгүй гэсэн заалт байдаг ба учир нь нийтийн хүртэх ашиг нь хувийн нууцлал буурсанаас гарч болох сөрөг нөлөөллөөс их байдаг. Мэдээлэл хамгаалалтын ямар ч дэглэм хувийн мэдээллийг нийтлэхийг бүрмөсөн зогсоодоггүй. (жишээ нь Нүд 11 ба Нүд 12-г үз).[117]

Энэ нь ЭӨ-н мэдээллийг хэр ихээр нийтэлбэл нийтийн ашиг сонирхолд нийцэх вэ гэсэн асуултад хүргэнэ. Мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоход гарч болох нэмэгдэл ашиг тусууд юу вэ, мөн энэ нь хувийн нууцад үзүүлж болох нөлөөлөлтэй харьцааны хувьд тэнцэх үү? Энэхүү танилцуулгын эхний хэсэгт гарч болох ашиг тусуудыг хураангуйлсан. ЭӨИТБ-г хангалттай олон оронд хэрэгжүүлээгүй байгаагаас үүдэн урт хугацааны эерэг нөлөөллийн талаарх баттай баримт цуглараагүй байгаа ба дээр өгүүлсэнчлэн зохисгүй үйлдлийг болиулж байгааг хэмжихэд хэцүү ч нийтийн бүртгэл нь нийтийн ашиг сонирхолд үйлчилнэ гэсэн ойлголттойгоор бодлого боловсруулагчид ажиллах нь зөв зохистой гэх хангалттай аргументууд бий.

Хувийн нууцын асуудлууд нь тухайн нөхцөл байдлаас ихээхэн хамарадаг. Жишээ нь ЕХ доторх өөр өөр гишүүн орнуудаас янз бүрийн хувийн нууцын асуудал болгоомжлолууд гарч ирж байна.[h] Англи ЕХ-ны гишүүн байх үедээ нийтийн бүртгэлийг их эсэргүүцэлгүйгээр

[h] Жишээлбэл, Нидерландад шүүхийн шийдвэр гаргах тухай өргөдөлд (дараа нь татгалзсан) хүүхдүүд баяжсан гэж сургуульдаа дээрэлхэж байсан жишээг дурьдсан байдаг (“Dagvaarding in Kort Geding”, Нууцлал нэгдүгээртт, 2021 оны 1-р сарын 5,, 27, https://www.privacyfirst.nl/images/stories/UBO/2021-01-05_KG_dagvaarding_UBO_register_PrivacyFirst_def.pdf); Германд гэр бүлийн бизнес эрхлэгчдийн холбоо шантааж, хүн хулгайлах айдсыг иш татав (Маркус Хен, "Холбооны засгийн газар корпорацийн лоббид ордог - компанийн мэдээлэл нууц хэвээр байна", 2017 оны 2-р сарын 22, Netzwerk Steuerjustigkeit, https://www.netzwerk-steuergerechtigkeit.de/bundesregierung-knickt-for/).

хэрэгжүүлж байсан. Эсрэгээрээ Англид багагүй эсэргүүцэл өрнөж ЕХ-ны олон оронд нийтлэг байдагтай адил хаалттай Үндэсний Таних Мэдээллийн Бүртгэл ба үнэмлэхийг иргэдэд бий болгосноор ажил дууcч байсан.[118]

Мэдээллийг нийтлэх нь зохистой, тэнцвэртэй, зөв зүйтэй гэдгийг үндэсний хувийн нууц, мэдээллийн хамгаалалтын арга хэмжээнийхээ хүрээнд орон болгон үнэлж дүгнэн ЭӨИТБ-г үүнд тулгуурлан хуульчлах нь чухал юм. Үүний хүрээнд хэрэгжүүлэгчид мэдээлэл нийтлэх **тодорхой зорилгыг тодорхойлох** ёстой.

## Мэдээлэл нийтлэх зорилгыг тодорхойлох

ЭӨ-н мэдээллийг мэдээлэл хамгаалалт болон хувийн нууцын хуулийн дагуу олон нийтэд нээлттэй болгохын тулд хууль боловсруулахдаа мэдээлэл цуглуулах, боловсруулах эрх зүйн үндэслэлийн хүрээнд тодорхой зорилгыг тодорхойлох хэрэгтэй. Хэрэгжүүлэгчид үүнд ерөнхийдөө хоёр аргачлалыг ашигладаг, тодорхой нарийн зорилгод тулгуурлан эрх зүйн үндэслэлийг тодорхойлох (жишээ нь санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх) эсвэл өргөн хүрээг хамарсан хариуцлага, нийтийн ашиг сонирхлын зорилго.

### Нүд 10: ЕХ дахь эцсийн өмчлөгчийн ил тод байдлын эрх зүйн үндэслэл

МУЭТЗ нь нарийн зорилгын жишээ юм. Үүнд ингэж заасан байдаг: “[...] санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглахаас урьдчилан сэргийлэх хууль ёсны зорилго бүхий шаардлагатай, тэнцвэртэй арга хэмжээ гэж үзвэл Гишүүн Орнуудын хувьд траст болон үүнтэй ойролцоо хуулийн бүтэцтэй байгууллагын эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийн хүртээмжийг өргөсгөх боломжтой юм.”[119]

Нийтийн ашиг сонирхолтой бүртгэлийг нийтийнх болгохын үнэ цэнийг МУЭТЗ ингэж тайлбарладаг: Эцсийн өмчлөгчийн мэдээллийг нийтэд нээлттэй болгосноор хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийн байгууллагууд зэрэг иргэний нийгмээр тухайн мэдээллийг илүү сайн шалгуулах боломж бүрдэж санхүүгийн тогтолцоон дахь бизнесийн гүйлгээнд итгэх итгэлцлийг хадгалахад хувь нэмэр оруулдаг. Гүйлгээнд оролцох боломжтой аливаа этгээд эцсийн өмчлөгч хэн гэдгийг мэдэх боломжтой болсоноор хэрэг мөрдөх ажиллагаанд туслах болон нэр хүндийн нөлөөгөөр дамжуулан компани, бусад хуулийн этгээд, хуулийн бүтэцтэй байгууллагуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглахтай тэмцэхэд хувь нэмэр оруулах боломжтой. Мөн дээрх зөрчилтэй тэмцэж буй гуравдагч орны эрх бүхий байгууллага зэрэг байгууллага болон санхүүгийн байгууллагад мэдээллийг түргэн шуурхай олгох боломжийг бүрдүүлнэ. Мэдээллийг хүртээмжтэй болгосноор мөнгө угаах, үүнтэй холбоотой зөрчил, терроризмын санхүүжүүлэлтийг мөрдөх ажиллагаанд тус болно.

Нарийн зорилгыг тодорхойлохын давуу тал нь ЭӨИТБ дээр улс төрийн хувьд өргөн дэмжлэгийг авахад хялбар болдог. Жишээлбэл ЕХ-ны хувьд үүнээс өөр аргаар ЭӨ-н нийтийн бүртгэлийг бүх гишүүн орноор хүлээн зөвшөөрүүлэх магадлал бага юм. Сул тал нь гэвэл энэ арга нь бодлогын бусад талбар дахь хэрэглээг хязгаарлан тодорхойлсон зорилгын нөлөөлөл, тэнцвэртэй байдлын талаар хэлэлцүүлэг хийхэд хүргэдэг. Үүнийг бичих үед бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгоход гарч болох ашиг тус нь гарч болох сөрөг нөлөөлөлтэй тэнцвэртэй харьцаатай гэдгийг харуулахыг засгийн газраас шаардсан, ЭӨ-н бүртгэлд хувийн мэдээллийг нийтлэхийг Ерөнхий Мэдээллийн Хамгаалалтын Зохицуулалтад (ЕМХЗ) үндэслэсэн эсэргүүцсэн хоёр заргыг Люксембург[120] хот дахь Европын Хууль Зүйн Шүүхэд гаргасан байгаа бөгөөд шүүх ажиллагаа явагдаж байна. Голланд улсад төрийн эсрэг шүүхийн хориг тавиулах хүсэлтэд нийтийн хүртээмжийг Мөнгө угаахын эсрэг болон терроризмыг санхүүжүүлэхтэй (ТС) тэмцэхээс илүүтэйгээр татвараас зайлсхийхтэй тэмцэхэд илүү ач холбогдолтой боловч энэ нь Захирамжид заасан зорилго биш гэж оруулжээ.[121] Уг хүсэлтийг буцаасан[122] боловч Ерөнхий Мэдээллийн Хамгаалалтын Зохицуулалт (ЕМХЗ) дор мэдээллийг зөвхөн тодорхойлсон зорилгоор ашиглахыг зөвшөөрдөг тул хүсэлт гаргах нөхцөлийг бүрдүүлж байна. Энэ нь мэдээлэл хамгаалах чухал зарчим боловч ашиглах зориулалтыг нь хянах боломжгүй тул аливаа өөр хэрэглээнд зориулан лицензлэгдсэн бол хувийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоход хэрэгжүүлэхэд хэцүү юм. Үүнтэй нэгэн адил нийтийн ЭӨ-н мэдээллийг ЕХ-ны Төрийн Мэдээллийн (ТМ) Захирамжийн дор эдийн засгийн зорилгоор үнэгүй болгох талаарх хэлэлцэхэд их яригддаг нэг зүйл бол мэдээллийг МУЭТЗ-н дор нийтэд нээлттэй болгосон ч өөр зорилгын хүрээнд тэгсэн тул улс төрийн багагүй эсрэгүүцэлтэй тулгарсаар байх болно гэдэг юм.[123]

### Нүд 11: Кайманы арлуудын хуулийн судалгаа

2020 оны 12-р сарын 14-ний өдөр Английн Засгийн газар олон нийтэд нээлттэй компаниудын ЭӨ-н бүртгэлийг хэрэгжүүлэхийг Хилийн Чанадын Нутаг Дэвсгэрүүдээс (ХЧНД) шаардсан Зөвлөлийн Тушаалын төслийг нийтэлсэн.[124] Үүний дараа ХЧНД-үүд үүнийг хувийн нууцын үндсэн хуулийн эрхэд хэрхэн нийцүүлж хэрэгжүүлэх вэ гэдгийг бодож үзэх шаардлагатай болов. ХЧНД-үүдэд өгсөн техникийн дэмжлэгийн хүрээнд ОО Кайманы Арлуудын хуулийг хянан судлах даалгаврыг өгчээ. Уг хяналтаар үндсэн хууль дахь дараах Зүйлийг авч үзсэн:

> ***Хувийн ба гэр бүлийн амьдрал***
>
> *9.—(1) Төр иргэн бүрийн хувийн ба гэр бүлийн амьдрал, түүний гэр, холбоо харилцаа хүндэтгэнэ.*
>
> ...
>
> *(3) Аливаа нэг хуулийн заалт болон түүний эрхээр хийгдсэн аливаа зүйл нь (a) батлан хамгаалах, нийтийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийтийн эрүүл мэнд, хот, газар төлөвлөлт, аливаа нийтийн ашиг тусын төлөөх бүтээн байгуулалтын төлөө; (b) бусад иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор байсан бөгөөд үүнийг ардчилсан нийгэмд зөв зохистой гэж үздэг бол энэхүү хэсгийг зөрчөөгүйд тооцно;*
>
> ...

Тус үндсэн хууль нь хувийн нууцыг хүндэтгэсэн хэсэгтэй боловч хувийн нууцын баталгаа өгөөгүй ба хувийн амьдралд оролцсон тохиолдлыг ардчилсан нийгмийн үнэт зүйлийг үндэслэсэн бол төрийг хувийн амьдралд оролцож болох заалтыг оруулж өгчээ. Үүнд "компаний бүтцийг гэмт хэргийн зорилгоор зохисгүй ашиглах нь хууль сахиулахын үүднээс эрсдэлтэй тул эцсийн өмчлөгчийн мэдээллийг нийтлэх нь нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангах зорилгоор мэт санагдана" гэжээ.

Үүнээс гадна тус хяналт судалгаагаар 2017 оны Мэдээллийн Хамгаалалтын Хууль нь хувийн мэдээлэлтэй харьцах баттай хуулийн тогтолцоог олгодог боловч эмзэг хувийн мэдээлэлд үйлчлэхгүй тул мэдээлэл хамгаалах зарчим болон үндсэн хуульд нийцүүлэн хууль ёсоор нийтэлж болно гэж үзжээ. Мөн Зүйл 4-т заасан мэдээллийг нийтлэх нь компаниудыг хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх тодорхой зорилготой бөгөөд мэдээллийг нийтлэхдээ 2017 оны Хуульд заасан мэдээлэл хамгаалалтуудыг чандлан мөрдөх тул "хувийн нууцыг хүндэтгэх 9-р Догол мөрийн эрх зөрчигдөөгүй" гэж ямар ч шүүх үзэх нь баараггүй гэжээ. [...] Засгийн газрын хувьд ЭӨ-н мэдээллийг нийтлэх нь зөв зохистой учраас ийм мэдээллийг нийтлэх нь хувийн нууцад халдах ч Үндсэн хуулийг зөрчсөн хэрэг болохгүй."[125]

Эсрэгээрээ зарим орнууд эрх зүйн өргөн хүрээг хамарсан зорилгыг баримтлах аргыг хэрэгжүүлсэн байдаг (Нэгдсэн Вант Улс нь Ерөнхий Мэдээллийн Хамгаалалтын Зохицуулалт (ЕМХЗ) хүчин төгөлдөр болох үед ЕХ-ны гишүүн байсан ба үүнийг улсын хууль болгосон). Гэсэн хэдий ч үүнд оруулсан тодорхой өөрчлөлтийн хүрээнд "хувийн мэдээллийг [...] ил болгох явдлыг Английн хэд хэдэн хууль, ялангуяа 2000 оны Мэдээллийн Эрх Чөлөөний Хуулиар (МЭЧХ) аль хэдийн баталсан" гээд "Албан баримт бичгүүдийг боловсруулах, олон нийтэд хүртээх" гэсэн хэсгийг нэмсэн байна.[126] Энэ үндэслэлээр "хууль, шударга ёсыг хэрэгжүүлэх" болон "ардчиллын үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа" зэрэг "нийтийн ашиг сонирхлын төлөөх ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хувийн мэдээллийг боловсруулах" талаар заалт бүхий 2018 оны Мэдээлэл Хамгаалалтын Хуулийн 8-р Хэсгийн хүрээнд ЭӨ-н мэдээллийг[127] нийтлэхийг зөвшөөрдөг.[128] ЕХ-той харьцуулахад Англид ЭӨ-н мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохыг олон нийтийн зүгээс эсэргүүцсэн эсэргүүцэл тийм ч өргөн хүрээтэй, хүчтэй байгаагүй. Мөн Англид хувийн мэдээллийг тодорхой зорилгоор олон нийтэд нээлттэй болгох соёл тавигдсан байсан. Зорилгыг нийтийн ашиг сонирхлын төлөө гэсэн өргөн хүрээг хамруулсан байсан тул ЭӨ-н мэдээллийг худалдан авалт зэрэг бодлогын шинэ чиглэлд өөр зорилгоор ашиглахад тийм их эсэргүүцэл болоогүй нь давуу тал болсон. Английн ЭӨИТБ-н хуулийг загвар болгосон, нийтлэг эрх зүйт Нигери улс ойролцоо аргачлалыг хэрэгжүүлсэн.

Улс орнуудын хувьд хариуцлагад тулгуурласан өргөн хүрээт зорилгыг баримтлах нь зүйтэй юм. Компани үүсгэн байгуулагч этгээдүүд хязгаарлагдмал хариуцлага зэрэг нийгмийн тодорхой ашиг тусыг хүртдэг тул төр болон нийгмээс тусгай зөвшөөрөл авдаг. Тэд олон нийтийн өмнө хариуцлага хүлээх ёстой бөгөөд иймийн тул тэдний бизнесийн үйл ажиллагааны нууцлал бага байх ёстой гэсэн аргумент гаргаж болно. Төрийн сангийн мөнгө хүлээн авагчийн ЭӨ-г төр нийтэлдэгтэй адил аливаа эдийн засагт үйл ажиллагаа явуулдаг бүх биш гэхэд олон компаниуд санхүүгийн бодлогын хүрээнд ямар нэг төрлийн татварын дэмжлэг авдаг.

ЭӨ-н мэдээлэл нь бодлогын янз бүрийн зорилгуудад янз бүрээр ашиглагдах боломжтой. ЭӨ-н мэдээллийн ашиг тусыг бүрэн дүүрэн гаргахыг хүсч буй орнууд өргөн хүрээг хамарсан зорилго бүхий эрх зүйн үндсийг тодорхойлох замаар үүнд цогц байдлаар хандах ёстой.

### Нүд 12: Канадын хуулийн дүн шинжилгээ[129]

2019 оны 10-р сард Канадын ТББ-уудын эвсэл Канадын эрх зүйн систем доторх ЭӨ-н мэдээллийг нийтэлж болох тал дээр хувийн нууцын шинжилгээг хийлгүүлжээ. Хамгийн их сонирхол татсан хэсэг нь Канадын Эрх, Эрх Чөлөөний Тунхаг Бичгийн 8-р хэсэг байлаа: “Зохисгүй нэгжлэг, эд хөрөнгө хураах явдлаас иргэн бүр хамгаалагдах эрхтэй” гэсэн энэ хэсэг нь төрийн зүй бус халдлагаас иргэний хувийн нууцыг зохих хэмжээнд хамгаалдаг.[130]

Уг судалгаагаар 8-р хэсгийн шинжилгээнд үндэслэн “эцсийн өмчлөгчийн бүртгэлийг бий болгох зорилгоор төрийн авахыг хүсч буй мэдээлэл нь хувийн нууцын өндөр зэрэглэлд орох магадлал бага юм. Уг мэдээлэл нь зохицуулалтанд байдаг компанийг зохисгүйгээр ашиглахыг бууруулах, ил тод байдлыг сайжруулах зорилготой компаний эцсийн өмчийг таниулсан мэдээллээр хязгаарлагдана” гэж дүгнэжээ. “Зохицуулалт болон цуглуулах мэдээллийн мөн чанарыг бодолцоход эцсийн өмчлөгчийн мэдээллийг төрөөс цуглуулах нь Тунхаг Бичгийн 8-р хэсгийн дор заасан хууль бус нэгжлэг, хөрөнгө хураалт болох магадлал бага” гэжээ.[131]

ЭӨ-н мэдээллийг цуглуулах нь 8-р хэсгийг зөрчсөн бөгөөд төр хувийн нууцад халдсан гэж тооцогдвол “компанийг илүү ил тод болгох, буруугаар ашиглагдахаас сэргийлэх төрийн болон нийгмийн чухал зорилтуудыг авч үзвэл иргэний хувийн нууцын эрхэд зөв зохистойгоор халдсан гэж шүүхээс үзэх магадлал өндөр” гэсэн дүгнэлтийг уг судалгаагаар гаргажээ.[132]

## Мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосноос гарч болох сөрөг үр нөлөөг дараах байдлаар бууруулах

ЭӨ-н мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохоос гарч болох ашиг тусыг хувийн нууцыг бууруулахаас гарч болох хор уршгийн нөлөөтэй жигнүүлж үзэх хэрэгтэй. Энэ нь орон оронд өөр өөр байх ба хэрэгжүүлэгч бүр гарч болох нөлөөг оролцогч талтай зөвшилцөн үнэлж дүгнэх шаардлагатай.[133] Хэрэгжүүлэгч нь мөн ямар асуудал, болгоомжлолууд бодит болохыг үнэлэх хэрэгтэй. Жишээлбэл Герман дахь зарим оролцогч талууд биеийн байцаалтын залилан, хүний хулгай гарч магадгүй гэх болгоомжлолыг илэрхийлсэн. Компаний захирлуудын хувьд биеийн байцаалтын залиланд өртөх эрсдэл харьцангуй өндөр байдаг тул тэдний талаарх мэдээллийг нийгмийн сүлжээ зэрэг интернэтэд аль хэдийн тавьсан үед энэ эрсдэл хамгийн ноцтой байдгийг судалгаа харуулсан байдаг.[134] Хүний хулгайн хувьд ЭӨ-н мэдээллийг нээлттэй бүртгэлд оруулсанаас ямар нэг хор хохирол гарсан жишээ бүртгэгдээгүй байна. Гэхдээ бүртгэлийг ихэвчлэн хөгжингүй орнууд орнуудад хэрэгжүүлсэн байдаг. Хэрэв ЭӨИТБ-н шинэчлэлүүдийг бусад нөхцөлд бодолцож үзвэл эдгээр нь тус тусын хор уршигтай учрах боломжтой. Жишээлбэл Мексик улс дахь хэрэгжүүлэлтийг дэмжсэн ОО-н туршлагаас харахад Мексикийн өөрийн хууль, аюулгүй байдлын орчинд үндэслэн (хүний хулгай) зэрэг хувийн аюулгүй байдлын эрсдэл талаарх болгоомжлох зүйлс бий юм. Төрийн албан хаагчийн хөрөнгийг ил болгох талаарх Мексикийн мэтгэлцээнд энэ талаар асуудал яригдсан. Индонез зэрэг ОО-н дэмжлэг үзүүлж буй бусад оронд мэдээлэл хамгаалалтын хуулийг боловсруулж байгаа тул тодорхойгүй байдлыг бий болгож байгаа. Ямар ч асуудал болгоомжлол гарсан бай хэрэгжүүлэгчид гарч болох хор уршгийг бууруулах хэд хэдэн алхамыг авч болно.

### Мэдээллийг цомхон болгох

Хэрэгжүүлэгчид мэдээллийг цомхон байлгах зарчмыг мөрдөн зөвхөн (бодлогын зорилгод нийцсэн) хангалттай, (зорилготой уялдаатай) ач холбогдолтой, (зорилгоос хэтрээгүй) шаардлага хангах мэдээллийг л цуглуулах хэрэгтэй. Мэдээлэл авах дэглэм нь шаардлагагүй, ялангуяа нарийн нууцлалын мэдээллийг (биеийн гаднах төрх, яс үндэс зэрэг) авах ёсгүй ба ийм мэдээллийг боловсруулах эрх зүйн босго өндөр байдаг.

## Шаталсан хандах эрх

Ихэнхи орнууд олон нийтэд албаныхантай харьцуулахад арай бага багц мэдээллийг нээлттэй болгодог. Үүнийг давхарга бүхий нэвтрэлт гэж болно. Жишээ нь олон нийт аливаа этгээдийн татвар төлөгчийн дугаарыг харах шаардлагагүй ч албаныханд энэ мэдээлэл хэрэгтэй байж болно. Хамгийн цомхон боловч нийтийн хяналтыг хангахад шаардлагатай мэдээллийг л нийтлэх.[135] Энэ нь өөр өөр компаний эцсийн өмчлөгч нэг хүн байгаа тохиолдолд өмчлөгч бүрийг харах, өөр өөр хүн байгаа тохиолдолд эцсийн өмчлөгчдийг ялгах боломжтой байх хэмжээний мэдээллийг нийтлэхийг хэлнэ. Иймд ихэвчлэн төрсөн он сар, харъяалал, оршин суугаа орон зэрэг нэмэлт мэдээллийг олон нийтэд нээлттэй болгодог. Хүснэгт 2.1 мөн Хүснэгт 2.2 Европын хоёр орны албаныхан болон олон нийтэд нээлттэй мэдээллийн хэсгүүдийг харьцуулж харуулна.

## Хүснэгт 2. Улс орны харьцуулалт

### Хүснэгт 2.1. Их Британи[137]

| Нийтэд нээлттэй мэдээлэл | Эрх бүхий этгээдүүдэд нээлттэй мэдээлэл |
|---|---|
| Төрсөн сар ба жил | Төрсөн өдөр бүтнээр |
| Үйлчилгээний хаяг, оршин суугаа улс | Үйлчилгээний хаяг, оршин суугаа бүтэн хаяг |
| Иргэншил | Иргэншил |
| ЭӨ эхэлсэн өдөр | ЭӨ эхэлсэн өдөр |
| Тухайн хүний мэдээллийг олон нийтэд ил болгохоос хамгаалах хүсэлт гаргасан эсэх | Тухайн хүний мэдээллийг олон нийтэд ил болгохоос хамгаалах хүсэлт гаргасан эсэх |
| Оруулсан сонирхлын мөн чанар, цар хүрээ (хүрээ) | Оруулсан сонирхлын мөн чанар, цар хүрээ (хүрээ) |

### Хүснэгт 2.2. Нидерланд[138]

| Нийтэд нээлттэй мэдээлэл | Эрх бүхий этгээдүүдэд нээлттэй мэдээлэл |
|---|---|
| Төрсөн сар ба жил | Төрсөн өдөр, газар, улс |
| Оршин суугаа улс | Оршин суух бүтэн хаяг |
| Иргэншил | Иргэншил |
| ЭӨ эхэлсэн өдөр | ЭӨ эхэлсэн өдөр |
| Тухайн хүний мэдээллийг олон нийтэд ил болгохоос хамгаалах хүсэлт гаргасан эсэх | Тухайн хүний мэдээллийг олон нийтэд ил болгохоос хамгаалах хүсэлт гаргасан эсэх |
| Оруулсан сонирхлын мөн чанар, цар хүрээ (хүрээ) | Оруулсан сонирхлын мөн чанар, цар хүрээ (хүрээ) |
| | Иргэний үйлчилгээний дугаар эсвэл гадаадын татварын дугаар (TIN) |
| | эцсийн өмчлөгчийн хэн болохыг баталгаажуулсан нэг буюу хэд хэдэн баримт бичгийн хуулбар (UBO) |
| | Эзэмшиж буй ашиг сонирхлын шинж чанар, цар хүрээг харуулсан нэг буюу хэд хэдэн баримт бичгийн хуулбар (жишээ нь тухайн хүнийг яагаад UBO гэж ангилсан гэх мэт) |

## Хамгаалалтын дэглэм

Мөн хэн нэгэн тэгш бус эрсдэл хүлээж буй нөхцөлд мэдээллийг нийтлэхээс чөлөөлөх замаар гарч болох сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой. Энэ нь олон ЭӨИТБ-н дэглэмд нийтлэг байдаг зүйл юм. Мөн мэдээллийг нийтлэснээр гарч болох эрсдэлүүдийг бууруулахад чиглэх ёстой. Жишээ нь хэн нэгэн хүн тодорхой хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болохыг мэдэх г.м. Жишээлбэл хэн нэгэн хүн тодорхой шашны байгууллагын гишүүн бөгөөд тухайн шашны зарчимтай зөрчилддөг үйл ажиллагаа явуулдаг компаний эцсийн өмчлөгч байж болно. Хамгаалалтын дэглэмд аливаа хувийн мэдээллийг нийтэлсэнээр гарах эрсдэлүүдийг оруулах ёстой.  Жишээлбэл бусдын дарамтанд орж мөрдөгдөж байгаа хүн өөрийн нэр, оршин суугаа хаягаа нэг доор нийтлүүлэхгүй байх бодит шаардлагатай юм. Хамгаалалтын дэглэм нь баримтаар нотлогдож байгаа тохиолдолд нийтлэгдэхийн өмнө зарим эсвэл бүх мэдээллийн хэсгийг хамгаалуулах хүсэлт гаргах бололцоог олгодог хүсэлт гаргах системтэй байх ёстой. Мэдээлэл ил болгох дэглэмд ноцтой цоорхойнуудыг үүсгэхгүйн тулд үүнийг нарийн тодорхойлсон нөхцөлийн дагуу шүүн хянадаг байх ёстой.

### Нүд 13: Английн Томоохон хяналтын эрхтэй этгээдүүдийг хамгаалах дэглэм

Английн хамгаалалтын дэглэм нь "дарамт, хүчирхийлэлд өртөх ноцтой эрсдэл байгаагаа" харуулж чадах аливаа хувь хүний оршин суугаа хаяг эсвэл бүх мэдээллийг хамгаалах боломжтой. Хүсэлтийг цаг тухайд нь хянаж үзнэ.

2016 оны 4-р сараас 2019 оны 1-р сарын хооронд бүх мэдээллийг хамгаалах 447 хүсэлт гаргасан байна. Зөвхөн 16% нь зөвшөөрөгдсөн (40%-н шийдвэр хүлээгдэж байна). 456 хүсэлтийг хаягаа хамгаалуулахаар гаргасны 88% нь зөвшөөрөгдсөн нь бүрэн хамгаалалт илүү өндөр босготой болохыг харуулж байна. Албаныхан хамгаалагдсан мэдээллийг харах хүсэлт гаргаж болох ч дээрх хугацаанд ийм хүсэлт гараагүй байна.[136]

# Дүгнэлт

Нийтийн ЭӨ-н бүртгэлийг хэрэгжүүлж буй болон хаалттай ЭӨ-н бүртгэлийг нээлттэй болгож буй орнуудын тоо нэмэгдэж байгаа нь ЭӨ-н мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохоос үүсэх үнэ цэнэ болон энэ үнэ цэнэ нь хувийн нууц, хувийн аюулгүй байдлын болгоомжлолоос давж гарах уу гэдэг тал дээр нилээдгүй мэтгэлцээнийг өрнүүлж байна.

Энэ танилцуулгаар ЭӨ-н бүртгэлийг олон нийтэд нээлттэй болгосноор хэд хэдэн хэрэглэгч бүлэгт мэдээлэл авах боломжийг олгон янз бүрийн бодлогын чиглэлд ашиг тусуудыг бий болгодгийг харуулав. Зарим бодлогын чиглэлд (санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх г.м.) төсөөллийн төгс тогтолцоонд хаалттай бүртгэлээр дамжуулан эдгээр ашиг тусуудаас хүртэх боломжтой юм.

Гэвч саяхны жишээнүүдээс харахад санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх дэлхий нийтийн тогтолцоо нь огтхон ч төгс биш бөгөөд төгс системийг бий болготол эдгээр ашиг тусуудыг нээлттэй бүртгэлээр дамжуулан түргэн хугацаанд хүртэх боломжтой юм. Худалдан авалт дахь хариуцлага зэрэг бодлогын нэмэлт зорилтуудад зөвхөн нээлттэй бүртгэлээр хүрэх боломжтой.

Хаалттай бүртгэлтэй харьцуулахад нийтийн бүртгэл илүү үр дүнтэй болохыг харуулсан цөөн баримтууд гарч ирж байгаа ч нийтийн бүртгэл нь нийтийн ашиг сонирхолд үйлчилдэг болохыг илтгэх хангалттай шалтгаанууд бий юм.

ЭӨ-н мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох талаар бодолцож буй орнууд мэдээллийг нийтэлсэнээс бий болох ашиг тусууд нь бүртгэлийг хэрхэн хэрэгжүүлсэнээс шалтгаалах болохыг мэдэж байх хэрэгтэй. Хэрэгжүүлж буй орон нь мэдээллийг эхлээд төв бүртгэлд нэгтгэн оруулах шаардлагатай. Хураамж, хязгаарлал бүхий зөвшөөрөл зэрэг саад нь мэдээллийн хэрэглээнд сөргөөр нөлөөлдөг тул эдгээр нь бүртгэлд байх ёсгүй юм. Мэдээлэлд нэвтрэх боломж болон бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөлгүйгээр зардлыг нөхөн авах боломжтой болохыг харуулсан баримт жишээнүүд гарч ирж байна. Олон нийтэд нээлттэй болгох хуулийг батлах тал дээр дэлхий нийтэд хэрэгжүүлсэн туршлагаас харахад ЭӨ-н мэдээллийг мэдээлэл хамгаалалт болон бусад холбогдох үүргүүдийн хамтаар ил болгохоор хуульчлах боломжтой юм. Хэрэгжүүлэгчид нь нарийн тодорхойлсон (Мөнгө угаахын эсрэг зэрэг тодорхой бодлогын чиглэл) гэхээсээ аль болох өргөн хүрээг хамарсан (хариуцлага, нийтийн ашиг сонирхол зэрэг) эрх зүйн үндэслэл, тодорхой зорилгыг тодорхойлох хэрэгтэй. Мэдээллийг ил болгосноор зөвхөн тухайн орны хувьд эцсийн өмчлөгчдөд учирч болох аюул нөхцөлийг бодолцон хамгаалалтын дэглэм зэргээр сөрөг нөлөөг аль болох бууруулах хэрэгтэй.

Үүнийг бичих үед нийтийн бүртгэлийн эсрэг хэд хэдэн заргыг шүүхээр хэлэлцэж байна. Зогсолтгүй нэмэгдэж буй мэдээллийн орчинд ЭӨИТБ-н зөв зохистой, эрх тэгш байдлыг шалгах нь чухал бөгөөд үүнээс гарах үр дүн нь мэтгэлцээнд нөлөөлөх нь дамжиггүй юм. ЭӨИТБ-г дэлхий нийтээр хараахан хэрэгжүүлээгүй байгаа тул бүх нөхцөлд гарч болох сөрөг нөлөөллүүдийн талаар дүгнэлт хийхэд эрт байна. Хэрэгжүүлэгчид болон ил тод байдлыг дэмжигчдийн аль алин нь мэдээллийг нийтлэх тал дээр сохроор өөдрөг байж болохгүй бөгөөд болгоомжлолыг нухацтай авч үзэх ёстой. Болгоомжлох зүйлс болон ашиг тусуудыг зохих ёсоор бодолцож үзсэнээр хэрэгжүүлэгчид нь тухайн нөхцөлд тохирсон, үр дүнтэй, аюулгүй ЭӨИТБ-н дэглэмийг боловсруулах боломжтой болох юм.

## Төгсгөлийн тайлбарууд

1 “Үндэсний сонгогчдын үйлчилгээний портал”, Энэтхэгийн сонгуулийн хороо, n.d., https://electoralsearch.in.

2 “Барилга байгууламжийн зөвшөөрөл олгох түүхэн газар”, NYC Open Data, 2020 оны хоёрдугаар сарын 8, https://data.cityofnewyork.us/Housing-Development/Historical-DOB-Permit-Issuance/bty7-2jhb.

3 “Хувийн нууц уу, нийтийн ашиг сонирхол уу? Компанийн эзэмшлийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх нь” В баг, Моторын өрөө, Нээлттэй эзэмшил, 2019 оны 3-р сар, 4, https://www.openownership.org/uploads/privacy-report-summary.pdf.

4 “Worldwide commitments and action”, Нээлттэй эзэмшил, n.d., https://www.openownership.org/map/.

5 “Ашигтай өмчлөлийг нуун дарагдуулах”, Egmont Group ба FATF, Парис, 2018 оны долдугаар сар, 32, https://egmontgroup.org/sites/default/files/filedepot/Concealment_of_BO/FATF-Egmont-Concealment-beneficial-ownership.pdf.

6 Майра Мартини, “Жолооны ард хэн байна? Компанийн өмчлөлийн дэлхийн стандартыг тогтоох нь”, Transparency International, 2019, 20, https://images.transparencycdn.org/images/2019_Who_is_behind_the_wheel_EN.pdf.

7 “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ – Канад”, Дөрөвдүгээр шатны харилцан үнэлгээний тайлан, FATF, Парис, 2016 оны есдүгээр сар, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer4/MER-Canada-2016.pdf.

8 “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ – Гана”, Хоёрдугаар шатны харилцан үнэлгээний тайлан, GIABA, Дакар, 2018, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer-fsrb/GIABA-Ghana-MER-2018.pdf.

9 “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ – Хонг Конг, Хятад”, Дөрөвдүгээр шатны харилцан үнэлгээний тайлан, FATF, Парис, 2019, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer4/MER-Hong-Kong-2019.pdf.

10 “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ – Австрали”, Дөрөвдүгээр шатны харилцан үнэлгээний тайлан, FATF, Парис, APG, Сидней, April 2015, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer4/Mutual-Evaluation-Report-Australia-2015.pdf.

11 “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ – Латви”, Тавдугаар ээлжийн харилцан үнэлгээний тайлан, MONEYVAL, Страсбург, 2018 оны 7-р сар, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer-fsrb/Moneyval-Mutual-Evaluation-Report-Latvia-2018.pdf.

12 “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ – Австрали”, Дөрөвдүгээр шатны харилцан үнэлгээний тайлан, FATF, Парис, APG, Сидней, April 2015, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer4/Mutual-Evaluation-Report-Australia-2015.pdf.

13 “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ – Хонг Конг, Хятад”, FATF-ын 4 дэх удаагийн харилцан үнэлгээний тайлан, Парис, 2019, www.fatfgafi.org/publications/mutualevaluations/documents/mer-hong-kong-china2019.html.

14 2020 оны 5-р сарын 21-ний өдөр Хууль сахиулах байгууллагын ажилтан Нээлттэй өмчтэй хийсэн ярилцлага.

15 2021 оны гуравдугаар сарын 2-ны https://www.openownership.org/events/the-open-ownership-principles-consultation Open Ownership зарчмуудын зөвлөгөөний хариу.

16 “Open data: Мэтт Хэнкокийн илтгэл”, GOV.UK, 2015 оны 12-р сарын 10, https://www.gov.uk/government/speeches/open-data-matt-hancock-speech.

17 Үз, жишээ: Гарет Дэвис, “Засгийн газрын хэмжээнд өгөгдөл ашиглахад тулгарч буй бэрхшээлүүд”, Үндэсний аудитын газар, 2019 оны 6-р сарын 21, https://www.nao.org.uk/wp-content/uploads/2019/06/Challenges-in-using-data-across-government.pdf.

18 “Ногоон тайлан: Төрийн худалдан авалтыг өөрчлөх нь”, GOV.UK, 2020 оны 12-р сарын 15, https://www.gov.uk/government/consultations/green-paper-transforming-public-procurement.

19 “Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл дэх GDPR-ийн хасалтын тойм”, Дижитал, соёл, хэвлэл мэдээлэл, спортын газар, 2017 оны 8-р сарын 7,https://iapp.org/media/pdf/resource_center/UK-GDPR-derogations.pdf; “Data Protection Act 2018”, Legislation.gov.uk, Section 8, 2018, https://www.legislation.gov.uk/ukpga/2018/12/section/8/enacted.

20 Шушан Дойдоян, “Армен дахь ашигтай өмчлөлийн дэвшил”, Арменийн эрх чөлөөний мэдээллийн төв, 2021 оны 4-р сарын 6, http://www.foi.am/en/news/item/2011/.

21 2021 оны 2-р сарын 25-ны "Компаниудын ордны шинэчлэл" сэдвээр Авлигатай тэмцэх, хариуцлагатай татварын APPG арга хэмжээний үеэр хийсэн тайлбар.

22 Арун Адвани, Эмма Чемберлен, Энди Саммерс, "Их Британид зориулсан баялгийн татвар", Баялгийн татварын хороо, 2020, https://www.wealthandpolicy.com/wp/WealthTaxFinalReport.pdf.

23 Роб Хаден, “EY-ийн дэлхийн залилангийн судалгаа”, LinkedIn, 2016 оны 4-р сарын 21, https://www.linkedin.com/pulse/eys-global-fraud-survey-2016-rob-haden?articleId=6128943671413923841.

24 "Илүү ухаалаг ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгох нь: Нийлүүлэлтийн гинжин хэлхээний харагдах байдлыг нэмэгдүүлэх, тасалдлыг багасгахад туслах хиймэл оюун ухаан болон блокчейн хүч" IBM, 2019 оны 10-р сар, https://www.ibm.com/downloads/cas/EYZ5BG4R.

25 Пол Мэй, "Эхлэх тайлан: Хувийн хэвшлийн зүгээс ашиг хүртэх өмчлөлийн өгөгдлийг ашиглах нь", Нээлттэй өмчлөх эрх, 2020 оны 6-р сар (Нийтлэгдээгүй).

26 Дэвид М.Луна, “Нэргүй компаниуд хууль бус худалдааг санхүүжүүлэхэд тусалж, Америкийн бизнес, иргэдэд хохирол учруулдаг”, FACT эвсэл, 2019 оны 5-р сар, https://thefactcoalition.org/anonymous-companies-help-finance-illicit-commerce-and-harm-american-businesses-and-citizens.

27 “Хувийн аж ахуйн нэгжүүдийн ашиг тусын өмчлөлийн мэдээллийг ашиглах нь”, Cognitiks ба Нээлттэй өмчлөх эрх, 2021 (Удахгүй болох).

28 Петрус ван Дуйне, Жеки Харви, Лилия Гелемерова, Мөнгө угаах гэмт хэргийн гарын авлага (Лондон: Пальграв Макмиллан, 2018), 254.

29 "Нэргүй компаниудыг дуусгах: Ашигтай өмчийн ил тод байдлыг хангах замаар авлигатай тэмцэх, тогтвортой байдлыг дэмжих нь”, B Баг, 2015 оны 1-р сар, 8-9, https://bteam.org/assets/reports/B-Team-Business-Case-Ending-Anonymous-Companies-Report.pdf.

30 “БХГ-ын бүртгэлийн хэрэгжилтийн тойм”, Бизнес, эрчим хүч, аж үйлдвэрийн стратегийн газар, 2019 оны 3-р сар, 30, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/822823/review-implementation-psc-register.pdf.

31 Ibid, 31.

32 Таймон Кипе, Эва Окунбор нар, "Худалдан авалт дахь ашигтай өмчлөлийн мэдээлэл", Нээлттэй өмчлөгч, 2021 оны 3-р сар, 16, https://www.openownership.org/uploads/OO%20BO%20Data%20in%20Procurement.pdf.

33 "Хувийн аж ахуйн нэгжүүдийн ашиг тусын өмчлөлийн мэдээллийг ашиглах нь", Cognitiks ба Нээлттэй өмчлөх эрх, 2021 (Удахгүй болох).

34 Крис Робинсон, "ОҮИТБС-ын мэтгэлцээн" онлайн арга хэмжээний ишлэл: Яагаад буцах болов? Латин Америк ба Карибын тэнгисийн орнуудад ашиг хүртэх өмчлөлийн талаар олон нийтэд ил болгоход тулгарч буй саад бэрхшээлүүд, 2021 оны 3-р сарын 11, https://eiti.org/event/eiti-debates-why-pushback-barriers-to-public-disclosure-of-beneficial-ownership-in-latin.

35 "Олборлох түүхий эдийн худалдааны талаарх ESG-ийн зохих шалгалт, ил тод байдлын тайлан, RMF, 2021, https://www.responsibleminingfoundation.org/app/uploads/EN_RMF_DDAT_TRADING_2021_WEB.pdf; "Хувийн аж ахуйн нэгжүүдийн ашиг тусыг хүртэх өмчлөлийн мэдээллийг ашиглах нь", Cognitiks ба Нээлттэй өмчлөх эрх, 2021 (Удахгүй болох).

36 "Давосын компаниуд тахлын дараах ESG-ийн хүлээлтийг биелүүлэхийг уриалав", LexisNexis, 2021 оны 1-р сарын 21, https://internationalsales.lexisnexis.com/sg/news-and-events/companies-at-davos-urged-to-meet-esg-expectations-after-the-pandemic.

37 "Материал байдлын шинэ эрин үеийг хүлээн авах нь: ESG дахь өөрчлөлтийн хурдыг ашиглах нь", 2020 оны 3-р сар, Дэлхийн эдийн засгийн форум, 5, http://www3.weforum.org/docs/WEF_Embracing_the_New_Age_of_Materiality_2020.pdf.

38 Ibid, 9.

39 Үз, жишээлбэл: Че Сиданиус, "Яагаад пүүсүүд илүү их компанийн эзэмшлийн мэдээллийг хүсдэг вэ?" LinkedIn, 2020 оны 5-р сарын 13, https://www.linkedin.com/pulse/why-firms-want-more-company-ownership-data-che-sidanius.

40 "Хувийн аж ахуйн нэгжүүдийн ашиг тусын өмчлөлийн мэдээллийг ашиглах нь", Cognitiks ба Нээлттэй өмчлөх эрх, 2021 (Удахгүй болох).

41 Доминик Кавакеб, "ЕХ-нд ашиг хүртэх өмчлөлийн бүртгэлийг бий болгоход бага зэрэг ахиц гарсан", Global Witness, 2020 оны 3-р сарын 20, https://www.globalwitness.org/en/campaigns/corruption-and-money-laundering/anonymous-company-owners/5amld-patchy-progress/.

42 "Украины бүх бизнесийн талаархи мэдээлэл", YouControl, n.d., https://youcontrol.com.ua/sources/.

43 "Оролдоод ч хэрэггүй: Украины мэдээллийн төвийн хүсэлтээр шүүх YouControl-ээс өгөгдлийг устгахаас татгалзав", YouControl, 2019 оны 12-р сарын 6, https://youcontrol.com.ua/en/news/i-ne-namahaytes-sud-vidmovyv-u-vydalenni-danykh-z-youcontrol-na-vymohu-ukrayinskoho-data-tsentru/.

44 "Case Studies", YouControl, n.d., https://youcontrol.com.ua/en/cases/.

45 "Хувийн аж ахуйн нэгжүүдийн ашиг тусын өмчлөлийн мэдээллийг ашиглах нь", Cognitiks ба Нээлттэй өмчлөх эрх, 2021 (Удахгүй болох).

46 Судалгааг олон нийтэд нээлттэй биш боловч дараах хэсэгт иш татсан болно. Deloitte, "Нээлттэй өгөгдлийн удирдамжийн дагуу гишүүн улсуудаас авах боломжтой өндөр үнэ цэнэтэй мэдээллийн багцын жагсаалтад узүүлэх нөлөөллийн үнэлгээний судалгаа", Европын комисс, 2021 оны 1-р сарын 7, 136.

47 Ibid, 138.

48 "Компанийн ордны мэдээллийн хэрэглэгчийн үр өгөөжийг үнэлэх нь", Компанийн Хаус болон Бизнес, эрчим хүч, аж үйлдвэрийн стратегийн газар, 2019 оны 9-р сар, 4, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/833764/valuing-benefits-companies-house-data-policy-summary.pdf.

49 Ibid, 16.

50 Ibid, 5.

51 Nkirote Koome, "OCCRP: Авлигатай тэмцэхэд эрэн сурвалжлах сэтгүүл зүй, том өгөгдлийг ашиглах нь", Luminate, 2021 оны 2-р сарын 18, https://luminategroup.com/posts/blog/occrp-using-investigative-journalism-and-big-data-in-the-fight-against-corruption.

52 "Чехийн прокурорууд Ерөнхий сайд Андрей Бабис залилангийн хэргийг хэрэгсэхгүй болгожээ", DW, 2019 оны 9-р сарын 2, https://www.dw.com/en/czech-prosecutors-drop-fraud-probe-into-pm-andrej-babis/a-50255477.

53 "Agrofert-ийн тухай", Agrofert, https://www.agrofert.cz/en/about-agrofert; Ивета Касалика, "Чехийн хэвлэл мэдээллийн шинэ эзэд", Progetto Repubblica Ceca, 2014 оны 7-р сарын 28, http://www.progetto.cz/i-nuovi-padroni-dei-media-cechi/?lang=en; Михал Черни, "Чехийн вэбсайт дахь сурвалжлагчид: мэдээний серверүүдийн тойм", Лупа, 2008 оны 2-р сарын 13, https://www.lupa.cz/clanky/zpravodajci-na-ceskem-webu-prehled/; "Компанийн тухай", MAFRA, https://www.mafra.cz/english.aspx.

54 Даниел Моравек, "Бабиш Агрофертийг итгэлцлийн сан руу шилжүүлсэн, гэхдээ компани түүнд буцаж ирнэ", Подникател, 2017 оны 2-р сарын 3, https://www.podnikatel.cz/clanky/babis-prevedl-agrofert-do-sverenskych-fondu-firma-se-mu-ale-vrati/; "Хувьцаа эзэмшигч нь AGROFERT болон SynBiol компаниудын удирдлагад хувьцаагаа Итгэлцлийн байгууллагад шилжүүлэх тухай мэдэгдсэн", Агроферт, 2017 оны 2-р сарын 3, https://www.agrofert.cz/en/events-and-news/shareholder-informed-the-management-of-the-companies-agrofert-and-synbiol-on-the.

55 "Agrofert-ийн тухай", Agrofert, https://www.agrofert.cz/en/about-agrofert.

56 Ibid.

57 Дэвид Ондрачка, "Андрей Бабиш бол бидний хяналтын хүн (бенефициар эзэмшигч" гэж Агроферт хэлэв", Transparency International, 2018 оны 6-р сарын 22, https://www.transparency.org/en/press/andrej-babish-is-our-controlling-person-czech-republic; "Төрийн салбарын түншүүдийн бүртгэл", Бүгд Найрамдах Словак Улсын Хууль зүйн яам, 2017 оны 2-р сарын 1, https://rpvs.gov.sk/rpvs/Partner/Partner/HistorickyDetail/7859.

58 "Transparency International-ийн ташаа мэдээлэлд няцаалт өгөхүй, Агроферт, 2018 оны 6-р сарын 19, https://www.agrofert.cz/en/events-and-news/rebuttal-of-misinformation-from-transparency-international.

59 Дэвид Ондрачка, "Андрей Бабиш бол бидний хяналтын хүн (бенефициар эзэмшигч" гэж Агроферт хэлэв", Transparency International, 2018 оны 6-р сарын 22, https://www.transparency.org/en/press/andrej-babish-is-our-controlling-person-czech-republic.

60 Даниел Моравек, "Бабиш Агрофертийг итгэлцлийн сан руу шилжүүлсэн, гэхдээ компани түүнд буцаж ирнэ", Подникател, 2017 оны 2-р сарын 3, https://www.podnikatel.cz/clanky/babis-prevedl-agrofert-do-sverenskych-fondu-firma-se-mu-ale-vrati/.

61 Тодруулбал, журмын 57 дугаар зүйл (ЕХ, Евратом) No 966/2012, журмын 61 дүгээр зүйл (ЕХ, Евротом) 2018/1046: “Европын парламентын 2017 оны 9-р сарын 14-ний өдрийн ЕХ-ны байгууллагуудын ил тод байдал, хариуцлага, шударга байдлын тухай тогтоол, Европын парламент, 2017 оны 9-р сарын 14, https://www.europarl.europa.eu/doceo/document/TA-8-2017-0358_EN.html..

62 Якуб Дурр, "Аудитын эцсийн тайлан: Аудитын дугаар REGC414CZ0133", Европын комисс, 2019, 19, https://ec.europa.eu/regional_policy/sources/docoffic/official/reports/cz_functioning_report/cz_functioning_report_en.pdf.

63 Майкл В. Хадсон нар, “Дэлхийн банкууд олигархууд, гэмт хэрэгтнүүд, террористуудад үйлчилж АНУ-ын дарангуйллыг эсэргүүцдэг”, ICIJ, 2020 оны 9-р сарын 20, https://www.icij.org/investigations/fincen-files/global-banks-defy-u-s-crackdowns-by-serving-oligarchs-criminals-and-terrorists/.

64 Үз, жишээ: ““Нууцлал – UBO бүртгэлийг зөрчих нь тодорхойгүй байна”, Нууцлал нэгдүгээрт, 2020 оны 6-р сарын 15, https://www.privacyfirst.nl/aandachtsvelden/wetgeving/item/1193-privacyschendend-ubo-register-schiet-doel-voorbij.html.

65 Үз: Таймон Кипе, Эва Окунбор нар, "Худалдан авалт дахь ашигтай өмчлөлийн мэдээлэл", Нээлттэй өмчлөгч, 2021 оны 3-р сар, https://www.openownership.org/uploads/OO%20BO%20Data%20in%20Procurement.pdf. .

66 Үз, жишээ: Kim, P.S., Halligan, J., Cho, N., Oh, C. and Eikenberry, A. (2005) 'Оролцоонд суурилсан, ил тод засаглалын төлөө: Засгийн газрыг дахин бүтээх нь дэлхийн 6 дахь форумын тайлан, Төрийн удирдлагын тойм 65 (6): 646-654. 649; Hazell, R. Ба Worthy, B. (2009) ‘Эрх чөлөөний талаарх мэдээллийн төв засгийн газарт үзүүлэх нөлөө’, Эдийн засаг, нийгмийн судалгааны зөвлөл, Үндсэн хуулийн нэгж, Их сургуулийн коллеж, Лондон дахь шагналын тайлангийн хэвлэгдээгүй төгсгөл; Жон Гавента, Розмари МакГи нар, “Ил тод байдал ба хариуцлагын санаачилгад үзүүлэх нөлөө”, Хөгжлийн бодлогын тойм, 2013 оны 8-р сарын 2, https://assets.publishing.service.gov.uk/media/57a08aabed915d622c00084b/60827_DPRGaventaMcGee_Preprint.pdf; Засгийн газрын ил тод байдал, хариуцлагын нийгмийн ач холбогдлыг зан үйлийн линз ашиглан тусгах; Стефан Гриммелихуйсен, Альберт Мейжер, “Төрийн байгууллагын итгэл үнэмшилд ил тод байдлын нөлөө: Онлайн туршилтын нотолгоо”, Төрийн удирдлагын судалгаа, онолын сэтгүүл, 24(1):137-157, https://www.researchgate.net/publication/270814803_Effects_of_Transparency_on_the_Perceived_Trustworthiness_of_a_Government_Organization_Evidence_from_an_Online_Experiment.

67 Таймон Кипе, Эва Окунбор нар, "Худалдан авалт дахь ашигтай өмчлөлийн мэдээлэл", Нээлттэй өмчлөгч, 2021 оны 3-р сар, https://www.openownership.org/uploads/OO%20BO%20Data%20in%20Procurement.pdf.

68 Үз, жишээлбэл: Синтия О'Мурчу, Роберт Смит нар, “Гупта Их Британийн Ковидын зээлийг баталгаажуулахын тулд бизнесийн эзэнт гүрнийг бий болгосон”, Financial Times, 2021 оны 4-р сарын 15, https://www.ft.com/content/b2c846db-2537-47e3-a75d-5118c69ba54a.

69 Associated Press, “‘Бүр тийм биш:’ Бейрутын дэлбэрэлтийн хохирогчид үнэнийг хүсч байна”, “Америкийн дуу хоолой”, 2021 оны 2-р сарын 6, https://www.voanews.com/middle-east/not-every-time-beirut-blast-victims-want-truth.

70 “Бейрутын дэлбэрэлт: Өнөөг хүртэл бидний мэдэх зүйл”, BBC, 2020 оны 8-р сарын 11, https://www.bbc.com/news/world-middle-east-53668493.

71 Фелипе Аризон "Баривчлах тухай мэдээ" 11, Shiparrested.com, 2015 оны 10-р сар, https://shiparrested.com/wp-content/uploads/2016/02/The-Arrest-News-11th-issue.pdf.

72 Ibid.

73 “Бейрутын дэлбэрэлт: Өнөөг хүртэл бидний мэдэх зүйл”, BBC, 2020 оны 8-р сарын 11, https://www.bbc.com/news/world-middle-east-53668493.

74 "Жорж Хасвани", "Этстремизмтэй тэмцэх" төсөл, n.d., https://www.counterextremism.com/extremists/george-haswani.

75 Грэм Барроу, Рэй Блэйк, "Британийн хясаа ба Бейрутын тэсрэлт", The Dark Money Files подкаст, 2021 оны 1-р сарын 17, https://podcasts.apple.com/us/podcast/british-shells-and-the-beirut-blast/id1448635132?i=1000505495826.

76 Мартин Кенни, "Мартин Кенни: Нээлттэй компанийн UBO бүртгэлүүд нь санхүүгийн гэмт хэргийн эм биш юм" The FCPA Blog, 2018 оны 5-р сарын 7, https://fcpablog.com/2018/5/7/martin-kenney-open-company-ubo-registers-are-not-the-panacea/.

77 Таймон Кипе, “Ашиг хүртэх өмчлөлийн мэдээллийг баталгаажуулах”, Нээлттэй өмчлөх эрх, 7, https://www.openownership.org/uploads/OpenOwnership%20Verification%20Briefing.pdf.

78 “Товч мэдээлэл: Нээлттэй өгөгдөл болох бенефициар өмчлөх тохиолдол”, Нээлттэй өмчлөл, 3, https://www.openownership.org/uploads/briefing-on-beneficial-ownership-as-open-data.pdf.

79 Таймон Кипе, “Ашиг хүртэх өмчлөлийн мэдээллийг баталгаажуулах”, Нээлттэй өмчлөх эрх, https://www.openownership.org/uploads/OpenOwnership%20Verification%20Briefing.pdf.

80 "Бидний хариуцдаг компаниуд: Их Британийн нээлттэй мэдээллийн бүртгэл нь компанийн эзэмшлийн талаар бидэнд юу хэлдэг вэ? Global Witness, 2018 оны 7-р сар, https://www.globalwitness.org/en/campaigns/corruption-and-money-laundering/anonymous-company-owners/companies-we-keep/#chapter-0/section-0.

81 “Компанийн ил тод байдал, бүртгэлийн шинэчлэл: Компанийн ордны үүргийг нэмэгдүүлэх, Их Британийн аж ахуйн нэгжүүдийн ил тод байдлыг нэмэгдүүлэх хувилбаруудын талаар зөвлөлдөх уулзалт”, Бизнес, эрчим хүч, аж үйлдвэрийн стратегийн газар, 2019 оны 5-р сар, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/819994/Corporate_transparency_and_register_reform.pdf.

82 “Компанийн Ил тод байдал, Бүртгэлийн Шинэчлэл: Компанийн ордны үүргийг нэмэгдүүлэх, Их Британийн аж ахуйн нэгжүүдийн ил тод байдлыг нэмэгдүүлэх хувилбаруудын талаар зөвлөлдөх уулзалт”, Бизнес, эрчим хүч, аж үйлдвэрийн стратегийн газар, 2020 оны 9-р сарын 18, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/819994/Corporate_transparency_and_register_reform.pdf.

83 Үз, жишээ: Ж.Патрик Меагер, “Ази, Номхон далайн орнуудад авлигаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх байгууллагын арга хэмжээ: 31 харьяаллын тогтолцоо ба практик”, АХБ ба ЭЗХАХБ, 11, https://www.oecd.org/site/adboecdanti-corruptioninitiative/ADB-OECD-Corporate-Measures-to-Prevent-and-Detect-Corruption-ENG.pdf; Бианка Ваз Мондо, “Хариуцлага нь авлигаас урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл болох нь: Бразилийн хотын захиргаанаас авсан шинэ нотолгоо”, ECPR, 2015, https://ecpr.eu/Events/Event/PaperDetails/23591.

84 Жемма Картин, “Их Британи дахь оффшор бүс, Шотландын хязгаарлагдмал түншлэлийг авлига, мөнгө угаахад ашиглахад дүн шинжилгээ хийх нь”, Transparency International UK, 2017 оны 6-р сар, https://www.transparency.org.uk/sites/default/files/pdf/publications/Offshore_In_The_UK_TIUK_June_2017.pdf.

85 Жакси Гаскойн, "Мөнгө угаах схемд Шотландын хязгаарлагдмал түншлэлийг ашиглах нь", MLROs.com, n.d., https://mlros.com/the-use-of-scottish-limited-partnerships-in-money-laundering-schemes/; Дэвид Лиск, Ричард Смит, "Шотландын компаниуд Оросоос 4 тэрбум фунт стерлинг угаадаг байсан", The Herald, 2017 оны 3-р сарын 27, https://www.heraldscotland.com/news/15183346.scots-shell-companies-used-to-launder-4-billion-out-of-russia/.

86 Ibid.

87 “Их Британийн Ашиг хүртэх өмчлөлийн бүртгэлээс авсан сургамжийн тухай хатуу өгөгдөл”, Global Witness, 2019 оны 5-р сарын 30, https://www.globalwitness.org/documents/19733/GW.Fact_Sheet_on_UK_Register_Data_for_US.May302019_ w0hQoid.pdf.

88 Ibid.

89 Ниенке Пальстра, "Их Британийн компаниудын жинхэнэ эзэмшигчдийн бүртгэл үнэ цэнийг нь нотлох гурван арга зам", Global Witness, 2018 оны 7-р сарын 24, https://www.globalwitness.org/en/blog/three-ways-uks-register-real-owners-companies-already-proving-its-worth/.

90 “Ашиг хүртэх өмчлөлийг үр дүнтэй ил болгох зарчим”, Нээлттэй өмчлөл, n.d., https://www.openownership.org/principles/.

91 “Хуулийн этгээдэд ашигтай өмчлөх шилдэг туршлага”, ФАТФ, Парис, 2019 оны 10-р сар, 22, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/Best-Practices-Beneficial-Ownership-Legal-Persons.pdf.

92 Майра Мартини, “Жолооны ард хэн байна? Компанийн өмчлөлийн дэлхийн стандартыг тогтоох нь”, Transparency International, 2019, 3, https://images.transparencycdn.org/images/2019_Who_is_behind_the_wheel_EN.pdf.

93 “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх: Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс”, FATF болон OECD, 2010 оны 6-р сарын 25, 210-214, https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer/MER%20Brazil%20full.pdf. Тайлбар: Компанийн үндэсний бүртгэлд татварын албанд хадгалагдаж буй хувь хүний тухай BO мэдээлэл байдаггүй ч хуулийн этгээдийн бүх мэдээллийг агуулна.

94 “БХГ-ын бүртгэлийн хэрэгжилтийн тойм”, Бизнес, эрчим хүч, аж үйлдвэрийн стратегийн газар, 2019 оны 3-р сар, 34, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/822823/review-implementation-psc-register.pdf.

95 “Зохицуулалтын нөлөөллийн шинжилгээ: Хөрөнгийн биржид бүртгэлгүй компаниудын бенефициар эзэмшлийн тухай тодруулга”, HM Treasury болон DTI, 2002 оны 7-р сар, https://webarchive.nationalarchives.gov.uk/+/http:/www.hm-treasury.gov.uk/media/9/9/ownership_long.pdf.

96 “Төсөв 2021”, Канадын Засгийн газар, 4-р хэсэг, Бүлэг 10.1, https://www.budget.gc.ca/2021/report-rapport/p4-en.html#261.

97 Үз: “Ашиг хүртэх өмч болон авлигын орлогыг хянах нь: Нигерийн нотлох баримт – Төслийн завсрын тайлан”, Нортумбриягийн их сургууль ба Авлигын эсрэг дэлхийн шударга байдлын нотлох баримт (ACE) хөтөлбөр, n.d., https://ace.globalintegrity.org/wp-content/uploads/2020/11/FCDO-project-Interim-Report-Final.pdf.

98 Гана улсад BO-ын мэдээлэл одоогоор үнэ төлбөргүй бөгөөд эрх бүхий байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудад хүртээмжтэй байгаа ч олон нийтэд бага хэмжээний төлбөр төлж ашиглах боломжтой. Жемима Оуэр, "Вебинар" онлайн арга хэмжээний ишлэл: Африк дахь ашигтай өмчлөлийн ил тод байдлын талаарх өндөр түвшний хэлэлцүүлэг", 2021 оны 5-р сарын 19, https://eiti.org/event/beneficial-ownership-transparency-in-africa

99 Deloitte, 112.

100 Ibid, 114.

101 Ibid, 24.

102 Ibid, 116.

103 “Нээлттэй UBO бүртгэл (Англи хэвлэл): Нидерланд дахь 2018/843 удирдамжийн хэрэгжилтийн судалгаа, ICTRECHT, 2020 оны 5-р сарын 25, 44, https://openstate.eu/wp-content/uploads/sites/14/2020/06/25052020-Het-Open-UBO-Register-ENG-NL.pdf.

104 Грэм Барроу, Рэй Блэйк, "Британийн хясаа ба Бейрутын тэсрэлт", The Dark Money Files подкаст, 2021 оны 1-р сарын 17, https://podcasts.apple.com/us/podcast/british-shells-and-the-beirut-blast/id1448635132?i=1000505495826.

105 Ниенке Пальстра, “Их Британийн компаниудын жинхэнэ эздийн бүртгэлээс авсан 10 сургамж”, Global Witness, 2017 оны 10-р сарын 23, https://www.globalwitness.org/en-gb/blog/10-lessons-uks-public-register-real-owners-companies/; “Жилийн тайлан ба данс 2016/17”, Компанийн ордны 2017 оны 7-р сарын 18, 7, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/633763/CompaniesHouse_AnnualReport_2017_web_version.pdf..

106 Дэнни Ламмерхирт, “Өгөгдөл ашиглахаас зайлсхийх нь: Засгийн газар лицензийн нээлттэй нөхцөлийг хэрхэн хялбарчилж чадах вэ?” Нээлттэй Мэдлэг Интернэшнл, 2017 оны 12-р сар, https://research.okfn.org/avoiding-data-use-silos/

107 Https://opendefinition.org/licenses/ үз

108 “Зарчмууд”, Нээлттэй өмчлөл.

109 Deloitte, 112-118.

110 “ЕХ-ны хэмжээнд BO бүртгэлүүд хэр хүртээмжтэй вэ”, Transparency International, 2021 оны 5-р сар (Удахгүй болох).

111 Deloitte, 141.

112 Deloitte, 381.

113 Тухайлбал, Голланд, Герман, Итали. Үз: Deloitte, 119-120

114 "Компаниудын ордны бизнес төлөвлөгөө 2020-2021", Компанийн ордон, 2020 оны 9-р сарын 29, https://www.gov.uk/government/publications/companies-house-business-plan-2020-to-2021/companies-house-business-plan-2020-to-2021#our-finances-and-resources.

115 "Компаниудын байрны хураамж", Компанийн ордон, 2021 оны 1-р сарын 6, https://www.gov.uk/government/publications/companies-house-fees/companies-house-fees.

116 “Их Британид бизнес эрхлэхэд хялбар”, Дэлхийн банк, 2020, te.

117 Дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү: Адриана Эдмеадс-Жонс, Том Паркер, Том Уолкер нар, “Бенефициар өмчлөлийн ил тод байдал дахь өгөгдөл хамгаалалт ба нууцлал”, В Баг, Моторын өрөө, ба Нээлттэй Эзэмшил, 2019 оны 5-р сар, https://www.openownership.org/uploads/oo-data-protection-and-privacy-188205.pdf.

118 Алан Трэвис, "Иргэний үнэмлэхний схемийг 100 хоногийн дотор хасна", The Guardian, 2010 оны 5-р сарын 27, https://www.theguardian.com/politics/2010/may/27/theresa-may-scrapping-id-cards; “Identity cards are to be scrapped”, GOV.UK, 27 May 2010, https://www.gov.uk/government/news/identity-cards-are-to-be-scrapped.

119 “2018 оны 5-р сарын 30-ны өдрийн Европын Парламент ба Зөвлөлийн 2018/843 тоот заавар (ЕХ) 2018 оны 6-р сарын 19-ний Европын Холбооны албан ёсны сэтгүүл, 28, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32018L0843&from=EN.

120 “C-601/20 хэрэг”, Европын Холбооны Шүүх, 2020 оны 11-р сарын 13, https://curia.europa.eu/juris/showPdf.jsf?text=&docid=235961&pageIndex=0&doclang=EN&mode=lst&dir=&occ=first&part=1&cid=4974448; “Хэргийн C-37/20”, Европын Холбооны Шүүхийн шүүх, 2020 оны 1-р сарын 24, https://curia.europa.eu/juris/showPdf.jsf;jsessionid=B3B63A86DA4477C1773F9176D8CAD6E3?text=&docid=225905&pageIndex=0&doclang=EN&mode=lst&dir=&occ=first&part=1&cid=4970639.

121 “Dagvaarding in Kort Geding”, Нууцлал нэгдүгээрт, 2021 оны 1-р сарын 4, 6, https://www.privacyfirst.nl/images/stories/UBO/2021-01-05_KG_dagvaarding_UBO_register_PrivacyFirst_def.pdf.

122 “Uitspraken: ECLI: NL: RBDHA: 2021: 2457”, de Rechtspraak, 2021 оны 3-р сарын 18, https://uitspraken.rechtspraak.nl/inziendocument?id=ECLI:NL:RBDHA:2021:2457.

123 Deloitte, 366.

124 “Хилийн чанад дахь нутаг дэвсгэр: ашиг хүртэх өмчлөлийн нийтийн хүртээмжтэй бүртгэлийг батлах нь”, Гадаад, хамтын нөхөрлөл, хөгжлийн газар, 2020 оны 12-р сарын 14, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/943307/SAMLA_s51_Draft_Order_in_Council.pdf.

125 John McKendrick QC, “Кэйс судалгаа: Кайманы арлууд, Ашигтай өмчлөлийн мэдээллийг нийтлэх контекст дэх хувийн нууцын эрх ба мэдээллийн хамгаалалт, 2021 оны 2-р сар (Хэвлэгдээгүй).

126 “Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл дэх GDPR-ийн хасалтын тойм”, Дижитал, соёл, хэвлэл мэдээлэл, спортын газар, 2017 оны 8-р сарын 7, https://iapp.org/media/pdf/resource_center/UK-GDPR-derogations.pdf.

127 "Хувийн мэдээллийн дүрэм", Компанийн ордон, GOV.UK, n.d., https://www.gov.uk/government/organisations/companies-house/about/personal-information-charter.

128 “Өгөгдөл хамгаалах тухай хууль 2018”, Legislation.gov.uk, 2018 оны 8-р хэсэг, https://www.legislation.gov.uk/ukpga/2018/12/section/8/enacted.

129 Мора Жонсон, "Нийтийн ашиг тусын өмчлөлийн бүртгэл ба Канадын нууцлалын дэглэм: Эрх зүйн шинжилгээ", Канад, Татварын шударга байдлын төлөө Канадчууд, Транспэрэнси Интернэшнл Канад, 2019 оны 10-р сар., https://static1.squarespace.com/static/5c8938b492441bf93fdbc536/t/5eac6dd026b8946d37f7dde2/1588358609932/endsnowwashing-public-beneficial-ownership-registry.pdf.

130 Ibid, 16.

131 Ibid, 19.

132 Ibid, 19.

133 Үз: Том Таунсенд, “Бенефициар өмчлөлийн ил тод байдлын шинэчлэлд зориулсан үр дүнтэй зөвлөлдөх үйл явц”, Нээлттэй өмчлөгч, 2020 оны 6-р сар, https://www.openownership.org/uploads/open-ownership-effective-consultation-processes-for-bot.pdf.

134 “Хувийн нууц уу, нийтийн ашиг сонирхол уу? Компанийн эзэмшлийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх нь” В баг, Моторын өрөө, Нээлттэй эзэмшил, 2019 оны 3-р сар, 4, https://www.openownership.org/uploads/privacy-report-summary.pdf.

135 "Хангалттай дэлгэрэнгүй мэдээлэл" ОО зарчмыг үзнэ үү: “Хангалттай дэлгэрэнгүй”, Нээлттэй өмчлөл, n.d., https://www.openownership.org/principles/sufficient-detail/.

136 “БХГ-ын бүртгэлийн хэрэгжилтийн тойм”, Бизнес, эрчим хүч, аж үйлдвэрийн стратегийн газар, 2019 оны 3-р сар, 43, https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/822823/review-implementation-psc-register.pdf.

137 Sjoerd Peters and Gonnie Smelting, "UBO-бүртгэлийн үр нөлөөг баталгаажуулах замаар үүнийг олон нийтэд нээлттэй болгож, хандалтын хязгаарлалт багатай: UBO бүртгэлийн нийтийн хүртээмжтэй холбоотой зөвлөмжүүд”, Мэдээллийн хууль ба бодлогын лаборатори, Амстердам, 2020 оны 1-р сарын 31, 8, https://openstate.eu/wp-content/uploads/sites/14/2020/02/ILP-Lab-Ensuring-the-effectiveness-of-the-UBO-register-by-making-it-publicly-available-with-fewer-access-restrictions.pdf.

138 Ibid, 6.

**Зохиогч**

**Tymon Kiepe**

Хувь нэмэр оруулсан

Louise Russell-Prywata
Thom Townsend

**Редакторууд**

Cara Marks
Victor Ponsford

**Редакторууд**

Lakshmi Kumar,
Global Financial Integrity
Maíra Martini,
Transparency International
Sasha Caldera,
Publish What You Pay Canada

**Дизайн**

Convincible Media

**Орчуулагч**

Alboum Translation Services

**Хэвлэсэн**

Open Ownership

**openownership.org**

@openownership

c/o Global Impact, 1199 North Fairfax Street, Suite 300, Alexandria, VA 22314, USA